**БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН ТУШААЛ**

2018 оны 04 сарын 19 өдөр Дугаар 17 Номгон

## Тайлан баталгаажуулах тухай

Монгол Улсын Ерөнхий аудиторын 2017 оны А/188 тоот тушаалын тавдугаар хавсралтаар батлагдсан "Аймаг нийслэл дэх Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудиторт шилжүүлэх бүрэн эрх"-ийн 1.1, 2.4 дэх заалт, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2003 оны 53 дугаар тушаалаар батлагдсан "Гүйцэтгэлийн аудитын тайланг хянан баталгаажуулах журам"-ын 4.2 дахь заалтыг үндэслэн ТУШААХ нь:

Нэг. "Баянхонгор аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн 2017 оны төсвийн гүйцэтгэл"-д хийсэн гүйцэтгэлийн аудитын тайланг баталгаажуулсугай.

Хоёр. Гүйцэтгэлийн аудитаар өгсөн зөвлөмжийн биелэлтэнд хяналт тавьж ажиллахыг ахлах аудитор А. Цээням, аудитор Б.Цэрэнчимэд, Ж.Өсөхбаяр нарт даалгасугай.

ДАРГА Б. МӨНХБАТ

2517104

# Гүйцэтгэл, нийцлийн аудитын хураангуй тайлан

Огноо:2018.04.18

## Нэг. Ерөнхий мэдээлэл

| | | | |
|---|---|---|---|
| Аудитын код: | ҮАГ-САГ/2018/01-НТГ | Шалгагдсан байгууллага, нэгжийн нэр: | Аймгийн Засаг дарга |
| Аудит хийсэн бүтцийн нэгжийн нэр: | Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газар | Аудит хийсэн баг, албан тушаалтан | Ахлах аудитор А.Цээням, аудитор Б.Цэрэнчимэд, Ж.Өсөхбаяр |
| Аудитын нэр: | *Баянхонгор аймгийн төсвийн Ерөнхийлөн захирагчийн 2017 оны төсвийн гүйцэтгэл* | | |

## Хоёр. Аудитын үр дүн:

### 2.1 Аудитын зорилго, хамарсан хүрээ:

Баянхонгор аймгийн төсвийн Ерөнхийлөн захирагчийн 2017 оны төсвийн гүйцэтгэл үнэн зөв илэрхийлэгдсэн эсэхийг шалгаж дүгнэлт гарган, ҮАГ-т хүргүүлэн УИХ-д танилцуулахад аудитын зорилт чиглэгдлээ

### 2.2 Аудитын дүн:

2.2.1 Гол асуулт/аудитын дэд зорилт 1: Аймгийн төсвийн орлогын төлөвлөгөөний биелэлт

Хариулт1: Аймгийн ИТХ-ын 2016.12.02-ны өдрийн хуралдааны 4/02 дугаар тогтоол, сумын ИТХ-ын тогтоолоор 2017 онд аймгийн нийт орлого, санхүүжилтийн эх үүсвэрийг 60264,6 сая төгрөгөөр баталж, 3 удаагийн тодотголоор 9380,6 сая төгрөгөөр өөрчлөлт оруулан нийт 69645,2 сая төгрөгийн орлого оруулж, зарцуулахаар төсөв батлагдсан байна.

Хүснэгт 1. Төсвийн орлого, зарлагын төлөвлөгөөний өөрчлөлт саяам.төг

| № | | Үзүүлэлт | Анх батлагдсан төсөв | Тодотгосон төсөв | Өөрчлөлт |
|---|---|---|---|---|---|
| 1 | A | **Аймгийн нийт орлогын дүн** | **60,264.6** | **69,645.2** | **9,380.8** |
| 1 | 1 | **Орон нутгийн нийт орлогын дүн** | 8297,7 | 13448,4 | 5150,7 |
| 2 | 1.1 | **Урсгал орлогын дүн** | 6,652.6 | 8102,7 | 1450,2 |
| 3 | | *Татварын орлого* | *6,009.7* | 7210,5 | 1200,8 |
| 4 | | татварын бус орлогын дүн | 642.9 | 892.2 | 249.3 |
| 5 | 1.2 | ТБӨОрлого | 1,045.2 | 2433.3 | 1388.1 |
| 6 | 1.3 | Хандив, тусламжийн орлого | 300.0 | 2481.8 | 2181.8 |
| 7 | 1.4 | Хөрөнгийн орлого | 300,0 | 430,6 | 130,6 |
| 8 | 2 | Тусламжийн орлого | 51,745.6 | 53,206.8 | 1,461.2 |
| 9 | | Улсын төсвөөс санхүүгийн дэмжлэг | 11,082.6 | 12,251.4 | 1,168.8 |
| 10 | | Улсын төсвөөс ОНХС орлогын шилжүүлэг | 2,980.0 | 2,163.3 | (816.7) |
| 11 | | Улсын төсвөөс Тусгай зориулалтын шилжүүлэг | 37,559.5 | 38,651.3 | 1,091.8 |
| 12 | | ТЗШ-ийн байгууллагын өөрийн орлого | 123.5 | 140.8 | 17.3 |
| 13 | 3 | Урд оны үлдэгдлээс санхүүжих | 221.2 | 2,990.0 | 2,768.9 |

Баянхонгор аймгийн орон нутгийн орлогоор Сангийн яамнаас хуваарилан хянаснаар 2017 онд 5662,4 сая төгрөг оруулах төлөвлөгөө ирүүлснийг аймгийн ИТХ-ын 2016.12.02-ны өдрийн хуралдааны 4/02 тоот тогтоолоор аймагт төвлөрөх татварын орлогыг 4741,9 сая, татварын бус орлогыг 573,1 сая, хөрөнгө борлуулсны орлогыг 300.0 сая төгрөгөөр, сумдын ИТХ-ын хуралдааны тогтоолоор сумд төвлөрөх татварын орлогыг 2682,9 сая төгрөгөөр буюу аймгийн дүнгээр нийт 8297,9 сая төгрөгийн орлого оруулахаар төлөвлөсөн нь Сангийн яамнаас хуваарилан хянасанаас 2635,5 сая төгрөгөөр нэмэгдүүлэн баталсан байна.

Аймгийн ИТХ-ын хуралдаанаар төсөвт 3 удаа тодотгол хийж 5150,5 сая төгрөгөөр нэмэгдүүлж, 2017.11.27-ны өдрийн хуралдааны 7/01 дугаар тодотголоор орлогыг орон нутгийн татварын орлогыг 7210,5 сая, хөрөнгийн орлогыг 430,6 сая, татварын бус орлого 892,2 сая, төсөвт байгууллагын өөрийн орлогоор 2433,3 сая /үүнд: орон нутгийн төсөвт байгууллагын өөрийн орлогоос 133,5 сая, орон нутгийн зам ашигласны хураамжаас 116,1 сая, сум хөгжүүлэх сангийн зээлийн эргэн төлөлтөөс орох орлогыг 2183,7 сая/, хандив тусламжийн орлогоор 2481,8 сая нийт 13448.4 сая төгрөгөөр батлагдсан байна. Орон нутгийн орлогоор 2017 онд 13584,8 сая төгрөгийн орлого орж, орлогын төлөвлөгөөг 101,0 хувиар биелэсэн байна.

Хүснэгт 2. Орон нутгийн орлогын төлөвлөгөө, гүйцэтгэл Сая.төг

| Д/Д | Орлогын төрөл | орон нутгийн жилийн эцсийн тайлангаар | | | |
|---|---|---|---|---|---|
| | | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Төлөвлөгөөний биелэлтийн хувь | Зөрүү |
| 1 | А.Орон нутгийн нийт орлого | 13,448.4 | 13,584.8 | 101.0 | 136.4 |
| 2 | татварын орлогын дүн | 7641,1 | 7992,6 | 104,6 | 351,5 |
| 3 | Татварын бус орлого | 892,2 | 1143,4 | 128,2 | 251,2 |
| 3 | ТБӨО | 2,433.3 | 1,666.7 | 68.5 | (766.6) |
| 4 | Хандив | 2481.8 | 2,782.1 | 112.1 | 300.3 |

2.2.1 Гол асуулт/аудитын дэд зорилт 2: Аймгийн төсвийн Ерөнхийлөн захирагчийн 2017 оны төсвийн гүйцэтгэл, зардлын хэтрэлт, хэмнэлтийн шалтгаан

**Хариулт2:** *Аймгийн ТЕЗ-ийн санхүүгийн нэгтгэсэн тайлангаар 67343,9 сая төгрөгийг зарцуулж батлагдсан төсөвт зардлыг 2301,3 сая төгрөгөөр хэмнэсэн байна.*

Хүснэгт 7. Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2017 оны төсвийн гүйцэтгэл

| № | Үзүүлэлт | 2017 он | | |
|---|---|---|---|---|
| | | Тодотгосон төсөв | Гүйцэтгэл | Зөрүү |
| А | 1 | 2 | 3 | 4=3-2 |
| | НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН | 69645.2 | 67343.9 | -2301.3 |
| | УРСГАЛ ЗАРДАЛ | 64202.1 | 62769.1 | -1433.0 |
| | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 50901.5 | 49597.6 | -1303.9 |
| | ТАТААС | 461.1 | 421.5 | -39.6 |
| | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 12839.5 | 12750.0 | -89.5 |
| | ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ | 5,443.1 | 4574.8 | -868.3 |

2017 онд урсгал үйл ажиллагааны зардлыг 1433,0 сая, хөрөнгийн зардлыг 868,3 сая төгрөгөөр төлөвлөснөөс дутуу зарцуулсан байна. Энэ нь ТШЗ болон сумыд ТЕЗ нь гэрээгээр хүлээсэн үүргээ бүрэн биелүүлээгүйгээс СХС-гаас олгосон зээлийн эргэн төлөлтийн орлого 874,8 сая төгрөг санд дутуу оруулсан ОНХС-гийн хөрөнгөөр хийхээр баталсан төсөл арга хэмжээ хэрэгжээгүйтэй холбоотой байна.

### 2.3 Аудитын гол дүгнэлт:

*Орон нутгийн татварын болон татварын бус орлогыг боломжит нөөц, бололцоонд тулгуурлан төлөвлөөгүйгээс анх батлагдсан дүнгээс 5150,7 сая төгрөгөөр давж биелсэн хэмжээгээр нь төсвийн зарлагыг нэмэгдүүлж байгаа нь төсвийг шаардлагатай арга хэмжээнд үр дүнтэй зарцуулахад эрсдэл дагуулж байна.*

### 2.4 Аудитын явцад илэрсэн зөрчил дутагдалын нэгтгэл:

| № | Аудитад хамрагдсан байгууллагын нэр | Алдаа, зөрчлийн /сая.төг/ | | Үүнээс | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | Тоо | Дүн | Зөвлөмж | Төлбөрийн акт | Албан шаардлага | Хууль хяналтын бусад байгууллагад шилжүүлсэн |
| А | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| 1 | Баянхонгор аймгийн ТЕЗ-ийн 2017 оны төсвийн гүйцэтгэлийн тайлан | 5 | 533,6 | 533,6 | | | |
| | ДҮН | 5 | 533,6 | 533,6 | | | |

## Гурав. Баталгаажуулалт

ХУРААНГУЙ ТАЙЛАНГ

ХЯНАСАН:

ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР: Б.МӨНХБАТ

АУДИТЫН МЕНЕЖЕР: Д.ЦЭЦЭГМАА

6417143544
ВЮА0067 9007423

БЭЛТГЭСЭН:

АХЛАХ АУДИТОР: А.ЦЭЭНЯМ

АУДИТОР: Б.ЦЭРЭНЧИМЭД

АУДИТОР: Ж.ӨСӨХБАЯР

**Төрийн аудитын байгууллагаас хийсэн санхүү, гүйцэтгэл, нийцлийн аудитын хураангуй тайлангийн хавсралт**

## Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

| Огноо: | 2018.04.18 | Аудитын нэр: | Баянхонгор аймгийн төсвийн Ерөнхийлөн захирагчийн 2017 оны төсвийн гүйцэтгэл | Аудитын код: | ҮАГ-САГ/2018/01-НТГ |
|---|---|---|---|---|---|
| Шалгагдсан байгууллагын нэр: | | | Баянхонгор аймгийн Засаг дарга | | сая төгрөгөөр |

| № | Аудитын зорилт, чиглэл | Тоо | Алдаа зөрчлийн утга | Мөнгөн дүн | Аудитын байгууллагаас гаргасан шийдэл | | | Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | Нэр | Огноо | Дугаар | Албан тушаал | Овог нэр |
| А | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 | 9 |
| 1 | Татварын орлого | 1 | *Орон нутгийн төсвийн орлогын төлөвлөгөөг Татварын хэлтсийн төсвийн орлогын мэдээтэй тулган шалгахад 9 сум 6 төрлийн татварын орлогыг 103.0 сая төгрөгөөр нэмэгдүүлэн сумын ИТХ-ын хуралдаанаар тодотгосон байхад аймгийн Татварын хэлтсийн татварын төлөвлөгөөний мэдээнд сумдын татварын байцаагч нар мэдээлээгүй байна.* | 103,0 | Зөвлөмж өгөв | 2018.04.18 | - | *Аймгийн ЗДТГ-ын СТСХ-ийн мэргэжилтэн, сумдын татварын байцаагч* | Ц.Дагвадорж, Б.Жамьяндорж |
| 2 | Татварын орлого | 1 | *Аймгийн Татварын хэлтэс аймгийн ИТХ-аар баталсан орон нутгийн өмч хөрөнгө борлуулсны орлогын 430.6 сая төгрөгний төлөвлөгөөг оруулж тооцоогүй байна* | 430,6 | Зөвлөмж өгөв | 2018.04.18 | | *Аймгийн ЗДТГ-ын СТСХ-ийн мэргэжилтэн* | Ц.Дагвадорж, Б.Жамьяндорж |

| A | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 | 9 |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 3 | СХС-ийн зээлийн эргэн төлөөлтийн орлого | 1 | Сум хөгжүүлэх сангийн зээлийн эргэн төлөлтийн орлогоор 2183,7 сая төгрөг оруулахаар тодотгож, гүйцэтгэлээр санд 1309,0 сая төгрөг оруулж орлогын төлөвлөгөөг 59,9 хувиар буюу 874,7 сая төгрөгөөр тасалсан байна. | 0 | Зөвлөмж өгөв | 2018.04.18 | | *Аймгийн Засаг дарга, Сумдын ТЕЗахирагчид* | - |
| 4 | Төсвийн төлөвлөлт,нэмэлт өөрчилөлт | 1 | Аймаг, сумын ИТХ-аар батлагдсан орон нутгийн орлогын төлөвлөгөөг төсвийн мэргэжилтнүүд Фискаль программд бүрэн шивж сан үүсгээгүйгээс Э-Тайланд буруу татагдаж аймгийн ТЕЗ-ийн санхүүгийн нэгтгэсэн тайлангийн төлөвлөгөөг дахин засварлагдсан, санхүүгийн нэгтгэсэн тайлангийн үзүүлэлтэд салбараар нь дүн шинжилгээ хийгээгүй байна. | 0 | Зөвлөмж өгөв | 2018.04.18 | | *Аймгийн Засаг дарга, ЗДТГ-ын СТСХ-ийн дарга, мэргэжилтэн* | Г.Батжаргал, С.Байгалмаа, Ц.Дагвадорж, А.Содномдаржаа |
| 5 | Зардал | 1 | Сумдын ЗДТГ-ын үйл ажиллагааны зардлаас суманд үйл ажиллагаа явуулж байгаа Цагдаагийн байгууллагын урсгал зардалд 46.0 сая төгрөгийг зарцуулсан нь Төсвийн тухай хуулийн 6.6.6 дахь заалтыг зөрчсөн байна. | 0 | Зөвлөмж өгөв | 2018.04.18 | | *Сумдын ЗДТГ-ын дарга нар* | |

Бэлтгэсэн: Ахлах аудитор А.Цээням

Анхан шатанд хянасан:Аудитын менежер Д.Цэцэгмаа

Хоёр дахь шатанд хянасан Тэргүүлэх аудитор: Б.Мөнхбат

БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

# БАЯНХОНГОР АЙМГИЙН ТӨСВИЙН ЕРӨНХИЙЛӨН ЗАХИРАГЧИЙН 2017 ОНЫ ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

Аудитын код: ҮАГ-САГ/2018/01-НТГ

***Дүгнэлт**: Орон нутгийн татварын болон татварын бус орлогыг боломжт нөөц, бололцоонд тулгуурлан төлөвлөөгүйгээс анх батлагдсан дүнгээс 5150,7 сая төгрөгөөр давж биелсэн хэмжээгээр нь төсвийн зарлагыг нэмэгдүүлж байгаа нь төсвийг шаардлагатай арга хэмжээнд үр дүнтэй зарцуулахад эрсдэл дагуулж байна.*

Баянхонгор хот 2018 он

*Тайланг бэлтгэсэн:*

***Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор***

***Б.Мөнхбат***

***Аудитын менежер***

***Д.Цэцэгмаа***

***Ахлах аудитор***

***А.Цээням***

***Аудитор***

***Б.Цэрэнчимэд***

***Ж.Өсөхбаяр***

***2018 оны 4 дүгээр сарын 19***

***Тайланг Аймгийн аудитын газрын Цахим хуудаснаас үзнэ үү:www.audit.mn***

***Аудитын тайлантай холбоотой асуудлаар нэмж тодруулах, асууж лавлах зүйл байвал 70442584, 70442424 дугаарын утсаар харилцана уу.***

***ХАЯГ:Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газар***

*Аймгийн ЗДТГ-ын байр, Баянхонгор сум, Баянхонгор аймаг-64000 Монгол Улс*

**АГУУЛГА**

**ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ........1**

**ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТЫН ТАЙЛАН........2**

Аудитын зорилт, хамарсан хүрээ........2

**АУДИТЫН ДҮН........3**

**Зорилт 1. Орон нутгийн орлогоор 2017 онд 13584,8 сая төгрөгийн орлого орж, орлогын төлөвлөгөөг 101,0 хувиар биелэсэн байна........3**

1.1 Орон нутгийн төсвийн орлого........3

1.2 Орон нутгийн төсвийн орлогын төлөвлөлтийн талаар........3

1.3 Гүйцэтгэлийн талаар........6

*1.3.1.Орон нутгийн татварын орлогын талаар:........7*

*1.3.2Төсөвт байгууллагын өөрийн орлогын талаар:........8*

***Зорилт.2 Аймгийн ТЕЗ-ийн санхүүгийн нэгтгэсэн тайлангаар 67343,9 сая төгрөгийг зарцуулж батлагдсан төсөвт зардлыг 2301,3 сая төгрөгөөр хэмнэсэн байна........9***

2.1 Аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн 2017 оны төсвийн гүйцэтгэл:....9

2.2 Орон нутгийн тусгай шилжүүлгийн талаар........13

2.3 Тусгай сан........13

*2.3.1 Замын сан:........13*

*2.3.2 Орон нутгийн хөгжлийн сан:........14*

*2.3.4 Сум хөгжүүлэх сан:........16*

2.4 Төсвийн шилжүүлэг........17

2.5 Ангилагдаагүй зардал........18

2.6 Орон нутгийн нэмэлт санхүүжилтийн дансны талаар........19

**АУДИТЫН ДҮГНЭЛТ........20**

**АУДИТЫН ЗӨВЛӨМЖ........21**

## ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ

| | |
|---|---|
| ҮАГ | Үндэсний аудитын газар |
| СХС | Сум хөгжүүлэх сан |
| ОНХС | Орон нутгийн хөгжлийн сан |
| ИТХ | Иргэдийн төлөөлөгчдийн хурал |
| СЯ | Сангийн яам |
| ТЕЗ | Төсвийн Ерөнхийлөн захирагч |
| ТШЗ | Төсвийн шууд захирагч |
| ЗДТГ | Засаг даргын тамгын газар |
| ЖДҮ | Жижиг дунд үйлдвэрлэл |
| ХХОАТ | Хувь хүний орлогын албан татвах |
| ЭМЯ | Эрүүл мэндийн яам |
| ХАХНХЯ | Хүн ам, хөдөлмөр, нийгмийн хамгаалалын яам |
| БСШУЯ | Боловсрол соёл шинжлэх ухааны яам |

## ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТЫН ТАЙЛАН

**Аудитын нэр:** Баянхонгор аймгийн төсвийн Ерөнхийлөн захирагчийн 2017 оны төсвийн гүйцэтгэл

1. **Аудитын код:** ҮАГ-САГ/2018/01-НТГ

**Аудитын зорилт, хамарсан хүрээ :** Баянхонгор аймгийн төсвийн Ерөнхийлөн захирагчийн 2017 оны төсвийн гүйцэтгэл үнэн зөв илэрхийлэгдсэн эсэхийг шалгаж дүгнэлт гарган УИХ-д танилцуулахад аудитын зорилт чиглэгдлээ. Уг зорилтыг хангахын тулд дараах чиглэлээр аудитыг гүйцэтгэв. Үүнд :

- Төсвийн орлого, зарлагын төлөвлөлтийн үндэслэл
- Төсвийн орлогын гүйцэтгэл
- Төсвийн зарлагын гүйцэтгэл

Үндэсний аудитын газраас ирүүлсэн төлөвлөгөөг үндэслэн Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газар дэд төлөвлөгөө хийж дараах зорилтыг хангах чиглэлээр аудитыг гүйцэтгэв. Үүнд :

- Аймгийн төсвийн орлогын төлөвлөгөөний биелэлт
- Аймгийн төсвийн Ерөнхийлөн захирагчийн 2017 оны төсвийн гүйцэтгэл, зардлын хэтрэлт, хэмнэлтийн шалтгаан
- Төсвийн гүйцэтгэлийн хавсралт судалгаа гаргах

4. **Аудитын арга зүй** : Аудитыг гүйцэтгэхэд төрийн хяналт, шалгалтын стандарт, гүйцэтгэлийн болон санхүүгийн аудитын арга зүйг ашиглан холбогдох албан тушаалтнуудтай ярилцлага хийх , асуулга, лавлагаа авах, тайлан баримт материалд тулгуурлан дүн шинжилгээ хийх арга зүйг ашиглав.

5. **Аудитад ашигласан хууль тогтоомж, шалгуур үзүүлэлтүүд :** Үүнд :

- Төсвийн тогтвортой байдлын тухай хууль
- Төсвийн тухай хууль
- Монгол улсын 2017 оны төсвийн тухай хууль
- Төрийн аудитын тухай хууль
- Аймаг, сумын ИТХ-ын хуралдааны тогтоолууд,
- холбогдох бусад хууль тогтоомж

6. **Аудит хийсэн хугацаа :** Аудитыг 2018 оны 4-р сарын 10-наас эхэлж 4-р сарын 19- ны хооронд хийж гүйцэтгэв..

7. **Аудит хийсэн багийн бүрэлдэхүүн :** Аудитыг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын тэргүүлэх аудитор Б.Мөнхбат удирдаж, аудитын менежер Д. Цэцэгмаа үе шатны ажлын хяналт тавьж, ахлах аудитор А.Цээням, аудитор Б.Цэрэнчимэд, Ж.Өсөхбаяр нар гүйцэтгэв.

## АУДИТЫН ДҮН

**Зорилт 1. Орон нутгийн орлогоор 2017 онд 13584,8 сая төгрөгийн орлого орж, орлогын төлөвлөгөөг 101,0 хувиар биелсэн байна.**

### 1.1 Орон нутгийн төсвийн орлого

Аймгийн ИТХ-ын 2016.12.02-ны өдрийн хуралдааны 4/02 дугаар тогтоол, сумын ИТХ-ын тогтоолоор 2017 онд аймгийн нийт орлого, санхүүжилтийн эх үүсвэрийг 60264,6 сая төгрөгөөр баталж, 3 удаагийн тодотголоор 9380,6 сая төгрөгөөр өөрчлөлт оруулан нийт 69645,2 сая төгрөгийн орлого оруулж, зарцуулахаар төсөв батлагдсан байна.

Улсын төсвөөс 2017 онд орон нутгийн төсөвт 12251.4 сая, тусгай зориулалтын шилжүүлгээр 38651.3 сая, ОНХНС-гаас 2163.3 сая, ТЗШ-ийн байгууллагуудын өөрийн орлогоор 140.8 сая, нийт 53206.8 сая төгрөгийн тусламж санхүүжилтийн орлого авахаар баталсан байна.

Хүснэгт 1. Төсвийн орлого, зарлагын төлөвлөгөөний өөрчлөлт

сая.төг

| № | | Үзүүлэлт | Анх батлагдсан төсөв | Тодотгосон төсөв | Өөрчлөлт |
|---|---|---|---|---|---|
| 1 | А | Аймгийн нийт орлогын дүн | 60,264.6 | 69,645.2 | 9,380.8 |
| 1 | 1 | **Орон нутгийн нийт орлогын дүн** | 8297,7 | 13448,4 | 5150,7 |
| 2 | 1.1 | **Урсгал орлогын дүн** | 6,652.6 | 8102,7 | 1450,2 |
| 3 | | *Татварын орлого* | *6,009.7* | 7210,5 | 1200,8 |
| 4 | | татварын бус орлогын дүн | 642.9 | 892.2 | 249.3 |
| 5 | 1.2 | ТБӨОрлого | 1,045.2 | 2433.3 | 1388.1 |
| 6 | 1.3 | Хандив, тусламжийн орлого | 300.0 | 2481.8 | 2181.8 |
| 7 | 1.4 | Хөрөнгийн орлого | 300,0 | 430,6 | 130,6 |
| 8 | 2 | Тусламжийн орлого | 51,745.6 | 53,206.8 | 1,461.2 |
| 9 | | Улсын төсвөөс санхүүгийн дэмжлэг | 11,082.6 | 12,251.4 | 1,168.8 |
| 10 | | Улсын төсвөөс ОНХС орлогын шилжүүлэг | 2,980.0 | 2,163.3 | (816.7) |
| 11 | | Улсын төсвөөс Тусгай зориулалтын шилжүүлэг | 37,559.5 | 38,651.3 | 1,091.8 |
| 12 | | ТЗШ-ийн байгууллагын өөрийн орлого | 123.5 | 140.8 | 17.3 |
| 13 | 3 | Урд оны үлдэгдлээс санхүүжих | 221.2 | 2,990.0 | 2,768.9 |
| 14 | Б | Зарцуулах төсөв | 60,264.6 | 69,645.2 | 9,380.6 |
| 15 | | Орон нутгийн төсөвт байгууллага, сан | 18,894.0 | 24,903.1 | 6,009.1 |
| 16 | | Тусгай зориулалтын шилжүүлгийн байгууллагад | 37,683.0 | 38,792.0 | 1,109.0 |
| 17 | | ОНХС- ын ТАХ | 3,687.6 | 5,950.1 | 2,262.5 |

### 1.2 Орон нутгийн төсвийн орлогын төлөвлөлтийн талаар:

Баянхонгор аймгийн орон нутгийн орлогоор УИХ-аас баталж, Сангийн яамнаас хуваарилан хянаснаар 2017 онд 5662,4 сая төгрөг оруулах төлөвлөгөө ирүүлснийг аймгийн ИТХ-ын 2016.12.02-ны өдрийн хуралдааны 4/02 тоот

тогтоолоор аймагт төвлөрөх татварын орлогыг 4741,9 сая, татварын бус орлогыг 573,1 сая, хөрөнгө борлуулсны орлогыг 300.0 сая төгрөгөөр, сумдын ИТХ-ын хуралдааны тогтоолоор сумд төвлөрөх татварын орлогыг 2682,9 сая төгрөгөөр буюу аймгийн дүнгээр нийт 8297,9 сая төгрөгийн орлого оруулахаар төлөвлөсөн нь Сангийн яамнаас хуваарилан хянасанаас 2635,5 сая төгрөгөөр нэмэгдүүлэн баталсан байна.

Хүснэгт 2. Орон нутгийн орлогын төлөвлөгөөг анх баталсан дүн /сая төгрөг/

| Татварын нэр төрөл | 2016 СЯ-ны хянасан суурь | Аймаг, сумын ИТХ-ын анх баталсан дүн | Зөрүү |
|---|---|---|---|
| Нийт орлогын дүн | 5662.4 | 8297.9 | 2635.5 |
| Татварын орлогын дүн | 5048.9 | 6009.8 | 960.9 |
| Орлогын албан татвар | 4182.8 | 4192.8 | 10.0 |
| Өмчийн татвар | 165.3 | 225.3 | 60.0 |
| АТБӨЯХАТ | 255.7 | 310.2 | 54.5 |
| Бусад татвар /төлбөр хураамж/ | 445.1 | 1281.5 | 836.4 |
| Татварын бус орлого | 613.5 | 1988.1 | 1374.6 |
| Хөрөнгө борлуулсны орлого | 0.0 | 300.0 | 300.0 |

Аймгийн ИТХ-ын хуралдааны 2016.12.02-ны өдрийн 4/02 тоот тогтоол, сумын ИТХ-ын тогтоолоор орон нутгийн татварын болон татварын бус орлогыг 6652,7 сая, хөрөнгийн орлогоор 300,0 сая, хандив тусламжийн орлогоор 300,0 сая, төсөвт байгууллагын өөрийн орлогоор 1045,2 сая /үүнд: орон нутгийн төсөвт байгууллагын өөрийн орлогоос 49,7 сая, ЖДҮ-ийн зээлийн эргэн төлөлтийн орлогоор 90,0 сая, орон нутгийн зам ашигласны хураамжаас 90,0 сая, сум хөгжүүлэх сангийн зээлийн эргэн төлөлтөөс орох орлогыг 815,5 сая, нийт орон нутгийн орлогыг 8297.9 сая төгрөгөөр орлогыг анх баталсан байна.

Аймгийн ИТХ-ын хуралдаанаар төсөвт 3 удаа тодотгол хийж 5150,5 сая төгрөгөөр нэмэгдүүлж, 2017.11.27-ны өдрийн хуралдааны 7/01 дугаар тодотголоор орлогыг орон нутгийн татварын орлогыг 7210,5 сая, хөрөнгийн орлогыг 430,6 сая, татварын бус орлого 892,2 сая, төсөвт байгууллагын өөрийн орлогоор 2433,3 сая /үүнд: орон нутгийн төсөвт байгууллагын өөрийн орлогоос 133,5 сая, орон нутгийн зам ашигласны хураамжаас 116,1 сая, сум хөгжүүлэх сангийн зээлийн эргэн төлөлтөөс орох орлогыг 2183,7 сая/, хандив тусламжийн орлогоор 2481,8 сая нийт 13448.4 сая төгрөгөөр батлагдсан байна.

Хүснэгт 3. Орон нутгийн орлогын тодотгон баталсан төлөвлөгөө /сая төгрөг/

| Татварын нэр төрөл | Аймаг, сумын ИТХ-ын анх баталсан дүн | Аймаг, сумын ИТХ-ын тодотгон баталсан дүн | Зөрүү |
|---|---|---|---|
| Нийт орлогын дүн | 8,297.9 | 13,448.4 | 5,150.5 |
| Татварын орлогын дүн | 6,009.8 | 7,210.5 | 960.7 |
| Орлогын албан татвар | 4,192.8 | 4,964.3 | 9.8 |
| Өмчийн татвар | 225.3 | 246.1 | 60.0 |
| АТБӨЯХАТ | 310.2 | 428.7 | 54.5 |
| Бусад татвар /төлбөр хураамж/ | 1,281.5 | 1,571.4 | 836.4 |
| Татварын бус орлого | 1,988.1 | 5,807.3 | 1,498.1 |
| Хөрөнгө борлуулсны орлого | 300.0 | 430.6 | 300.0 |

Сумдын санхүүгийн алба Төсвийн тухай хуулийн 66.1.4 "иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар баталсан орон нутгийн төсвийг түүнийг баталснаас хойш ажлын долоон өдрийн дотор аймаг, нийслэлийн Засаг даргад хүргүүлэх" гэсэн заалтын дагуу сумын ИТХ-ын хуралдааны төсөв баталсан тогтоолыг цаг хугацаанд нь бүрэн ирүүлээгүйгээс аймгийн ТЕЗ-чийн болон аймгийн Татварын хэлтсийн орлогын төлөвлөгөө зөрүүтэй мэдээлэгдэж, аудитын явцад хүндрэл учруулж байна.

*Тухайлбал: Орон нутгийн төсвийн орлогын төлөвлөгөөг Татварын хэлтсийн төсвийн орлогын мэдээтэй тулган шалгахад 9 сум 6 төрлийн татварын орлогыг 103.0 сая төгрөгөөр нэмэгдүүлэн сумын ИТХ-ын хуралдаанаар тодотгосон байхад аймгийн Татварын хэлтсийн татварын төлөвлөгөөний мэдээнд сумдын татварын байцаагч нар мэдээлээгүй байна. Үүнд: Галуут сум 31.5 сая, Баян-Овоо сум 9.0 сая, Эрдэнэцогт сум 9.5 сая, Бууцагаан сум 9.0 сая, Заг сум 0.8 сая, Өлзийт сум 11.9 сая, Хүрээмарал сум 1.0 сая, Баянбулаг сум 12.0 сая, Жинст сум 18.3 сая, төгрөгийн тодотгосон татварын орлогын төлөвлөгөөний мэдээг мэдээлээгүй байна.*

*Энэ нь Ан агнуурын татварын орлогын төлөвлөгөөг 14 сумд сумын ИТХ-ын хуралдаанаар нийтдээ 520,0 сая төгрөгөөр тодотгон баталсан байхад Аймгийн Татварын хэлтсийн ан агнуурын орлогын төлөвлөгөө 444,0 сая төгрөг буюу 76,0 сая төгрөгөөр зөрүүтэй байна.*

*Хүү торгуулийн орлогын төлөвлөгөөг аймаг, сумын ИТХ-ын хуралдаанаар нийтдээ 892,2 сая төгрөгөөр тодотгон баталсан байхад Аймгийн Татварын хэлтсийн орлогын төлөвлөгөө 943,1 сая төгрөг буюу 13,8 сая төгрөгөөр зөрүүтэй байна.*

*Мөн аймгийн Татварын хэлтэс аймгийн ИТХ-аар баталсан орон нутгийн өмч хөрөнгө борлуулсны орлогын 430.6 сая төгрөгний төлөвлөгөөг оруулж тооцоогүй байна.*

*Иймд цаашид зөрчлийг арилгах зөвлөмжийг аймгийн Засаг даргад хүргүүлэв.*

Мөн аймгийн төсвийн Ерөнхийлөн захирагчийн төсвийн гүйцэтгэлийн тайлангийн төлөвлөгөө зөрүүтэй татагдаж аудит хийхэд хүндрэл учирч цаг хугацаа

алдсан, Төсвийн тухай хуулийн 8.9.4-д заасан хугацаанд гаргаж ирүүлээгүй тул цаашид хуульд заасан хугацаанд ирүүлэх талаар зөвлөмж өгөв.

## 1.3 Гүйцэтгэлийн талаар:

Аймгийн дүнгээр 2017 онд орон нутгийн орлогоор анх 8297.9 сая төгрөг оруулахаар төлөвлөж, 5150.5 сая төгрөгөөр нэмж тодотгож, 13448.4 сая төгрөгийн орлого оруулахаар төлөвлөснөөс 13584.8 сая төгрөг оруулж, төлөвлөгөө 136.4 сая төгрөгөөр давж биелсэн байна.

**Хүснэгт 4. Орон нутгийн орлогын төлөвлөгөө, гүйцэтгэл** Сая.төг

| Д/Д | Орлогын төрөл | орон нутгийн жилийн эцсийн тайлангаар | | | |
|---|---|---|---|---|---|
| | | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Төлөвлөгөөний биелэлтийн хувь | Зөрүү |
| 1 | **А.Орон нутгийн нийт орлого** | 13,448.4 | 13,584.8 | 101.0 | 136.4 |
| 2 | **татварын болон татварын бус орлогын дүн** | 8,533.3 | 9,136.0 | 107.1 | 602.7 |
| 3 | **1.Аймгийн төсөв** | 4,953.7 | 5,294.4 | 106.9 | 340.7 |
| | 1. ЦХТАО /суутган-1/ | 4,977.0 | 5,268.7 | 105.9 | 291.7 |
| | Буцаан олголт | (772.0) | (771.4) | 99.9 | 0.6 |
| | 2. АТӨЯХАТ | 428.7 | 399.7 | 93.2 | (29.0) |
| | 3. Үл хөдлөх хөрөнгийн татвар | 200.0 | 247.6 | 123.8 | 47.6 |
| | 4.Газрын төлбөр | 120.0 | 149.8 | 124.8 | 29.8 |
| 2 | **2. Орон нутгийн төсөв** | 3,579.6 | 3,841.6 | 107.3 | 262.2 |
| 1 | **Хүн амын орлого** | 686.6 | 632.3 | 92.1 | (54.3) |
| | 1..ИОТТХ | 686.6 | 632.3 | 92.1 | (54.3) |
| 2 | **2. Үл хөдлөх хөрөнгө борлуулсны** | 72.5 | 90.4 | 124.7 | 17.9 |
| 2 | **Орон нутгийн өмчийн хөрөнгө борлуулсны орлого** | 430.6 | 315.1 | 73.2 | (115.5) |
| 3 | **3. Бууны татвар** | 46.1 | 52.7 | 114.2 | 6.5 |
| 4 | **5. Бусад төлбөр хураамж** | 1,451.4 | 1,607.8 | 110.8 | 156.3 |
| | а.УТХ | 221.2 | 231.7 | 104.7 | 10.5 |
| | в. Газрын дуудлага худалдаа | 2.5 | 8.2 | 325.4 | 5.7 |
| | д. Хог хаягдлын хураамж | 282.9 | 302.0 | 106.7 | 19.0 |
| | д.ус рашаан ашигласны төлбөр | 403.0 | 438.9 | 108.9 | 35.9 |
| | ё.Түгээмал тархацтай АМАТөлбөр | 14.7 | 8.5 | 57.6 | (6.2) |
| | з.Ан, амьтан агнуурын нөөц ашигласны | 520.0 | 603.0 | 115.9 | 82.9 |
| | й.Нохойны татвар | 7.1 | 9.0 | 126.7 | 1.9 |
| | е.Бусад татвар | | 6.7 | #DIV/0! | 6.7 |
| 6 | **Татварын бус орлого** | 892.2 | 1,143.4 | 128.2 | 251.2 |
| | Хүү торгууль | 892.2 | 1,143.4 | 128.2 | 251.2 |
| 7 | **ТБӨО** | 2,433.3 | 1,666.7 | 68.5 | (766.6) |
| | **Хандив** | 2481.8 | 2,782.1 | 112.1 | 300.3 |

Дээрхи судалгаанаас харахад орон нутгийн нийт орлого дүнгээрээ 136.4 сая төгрөгөөр, Орон нутгийн татварын орлого 351.6 сая төгрөгөөр буюу 104.6 хувиар, хүү торгуулийн орлого 251.2 сая буюу 128.2 хувиар давж биелсэн байна. Харин төсөвт байгууллагын өөрийн орлогын төлөвлөгөө 466,4 сая төгрөгөөр тасарсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн дагуу орон нутгийн төсвийн бүрэлдэхүүнд ОНХС, СХС-гийн орлого, зарлагыг оруулан баталж, гүйцэтгэлийг тайлагнах болсноор сангуудаас олгосон зээлийн эргэн төлөлт хуваарийн дагуу төлөгдөөгүйтэй холбоотой байна.

### 1.3.1.Орон нутгийн татварын орлогын талаар:

Орон нутгийн татварын орлогоор 2017 онд 7641.2 сая төгрөг оруулахаар төлөвлөж, гүйцэтгэлээр 7992.6 сая, хүү торгуулийн орлогоор 892.2 сая төгрөг оруулахаас 1143.4 сая төгрөг, нийт 8533,4 сая төгрөг оруулахаас 9136,0 сая төгрөг оруулж, орлогын төлөвлөгөөг 602,6 сая төгрөгөөр буюу 107,1 хувиар давуулан биелүүлсэн байна.

Орлогын төлөвлөгөөг нэр төрлөөр нь авч үзвэл үл хөдлөх хөрөнгө болон орон нутгийн өмчийн хөрөнгө борлуулснаас орох орлого 97,6 сая, АТӨЯХАТатвар 29.0 сая, ИОТХХ 54,4 сая, түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөр 6.2 сая төгрөгөөр тус тус тасарч, бусад нэр төрлийн орлого биелсэн байна.

График №1




Аймгийн Татварын хэлтсээс татварын орлогын төлөвлөгөөний биелэлтийн талаар судалгаа авч дүн шинжилгээ хийж давсан болон тасарсан орлогын шалтгааныг тодруулав. Үүнд:

***<u>Давсан орлогын талаар</u>***

- *Цалин хөлс болон түүнтэй адилтгах орлого 291,7 сая төгрөгөөр давж 5268,7 сая төгрөг орсон нь төрийн албан хаагчдад урамшуулал, нэг удаагийн тэтгэмж олгосонтой холбоотой.*

- *Ан агнуурын нөөц ашигласны орлого 82,9 сая төгрөгөөр давж 603,0 сая төгрөгийн орлого төвлөрсөн нь зөвшөөрлийн хураамжийн орлого сумдад орсон.*

- *Хүү торгуулийн орлого 251,2 сая төгрөгөөр давж 1143,4 сая төгрөг төвлөрсөн нь хяналтын байгууллагуудаас орлого төвлөрсөн мөн иргэдийн хадгаламжийн хүүгийн орлого тухайн дансанд төвлөрснөөс шалтгаалсан байна.*

***<u>Тасарсан орлогын талаар</u>***

- *АТӨЯХАТатвар 29.0 сая төгрөгөөр тасарсан нь 2017 онд Автотээврийн болон өөрөө явагч хэрэгслийн албан татварын тухай хууль болон Агаарын бохирдлын төлбөрийн тухай хуулийн хэрэгжилтийг хангах зорилгоор ТЕГ-ын даргын 2017.01.09-ны өдрийн А/08 тоот тушаал, аймгийн Засаг даргын 2017.03.16-ны өдрийн А/196 тоот захирамж, ТЕГ-ын тушаалаар баталсан удирдамжийн дагуу хуулийн этгээд, хувь хүний эзэмшилд байгаа АТБӨЯХАТ, агаарын бохирдлын төлбөр, авто зам ашигласны төлбөрийг хураах ажлыг нутаг дэвсгэрийн зарчмаар аймгийн хэмжээнд зохион байгуулсан гэсэн тайлбар ирүүлсэн.*

*Аудитаар өгсөн зөвлөмжийн дагуу ажлаа зохион байгуулаагүй нөөц бололцоог дутуу ашигласантай холбоотой байна.*

- *Үл хөдлөх хөрөнгө болон орон нутгийн өмчийн хөрөнгө борлуулснаас орох орлого 97,6 сая төгрөгөөр тасарсан нь төлөвлөсөн зарим хөрөнгийн дуудлага худалдааг явуулаагүй*

- *ИОТХХ 54,4 сая төгрөгөөр тасарсан нь иргэдийн хадгаламжийн хүүгийн орлогын гүйцэтгэлийг хүү торгуулийн орлогоор Төрийн сан буруу тайлагнасан. Цаашид Төрийн сантай орлогыг тулган тайлагнаж байх зөвлөмж хүргүүлэв.*

- *Түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөр 6.2 сая төгрөгөөр тасарсан нь Өлзийт сумын нутагт үйл ажиллагаа явуулдаг түгээмэл тархацтай ашигт малтмалын тусгай зөвшөөрөл эзэмшигч тоосгоны үйлдвэр, хайрга ашиглагч зам ангийн компаниуд нь тогтмол үйл ажиллагаа явуулаагүй зэргээс шалтгаалсан.*

*Аудитаар өгсөн зөвлөмжийн дагуу ажил зохион байгуулаагүй, аймгийн төвд баригдаж байгаа болон засварын ажил хийж байгаа ААН-ээс тус хураамжийг бүрэн хураан авч чадахгүй нөөц бололцоог ашиглахгүй байгаатай холбоотой байна.*

### 1.3.2Төсөвт байгууллагын өөрийн орлогын талаар:

Аймгийн дүнгээр төсөвт байгуулагын өөрийн орлогоор 4915.1 сая төгрөг оруулахаас 4448.8 сая төгрөг оруулж 466.4 сая төгрөгөөр төлөвлөгөө тасарсан байна.

Хүснэгт 5. Төсөвт байгууллагын өөрийн орлогын төлөвлөгөө, гүйцэтгэл сая.төг

| № | | Орлогын төрөл | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү | Хувь |
|---|---|---|---|---|---|---|
| | | **Төсөвт байгууллагын өөрийн орлого** | **4915.1** | **4448.8** | **-466.4** | **90.5** |
| 1 | Үүнээс | Төсөвт байгууллагын өөрийн орлого | 133.5 | 240.2 | 106.7 | 179.9 |
| 2 | | Орон нутгийн зам ашигласны хураамжийн орлого | 116.1 | 117.5 | 1.4 | 101.2 |
| 3 | | Сум хөгжүүлэх сангийн орлого | 2183,7 | 1309.0 | -874,7 | 73.2 |
| 4 | | Хандивын орлого | 2481,8 | 2782.1 | 300,3 | 96.7 |

2017 онд Сум хөгжүүлэх сангийн зээлийн эргэн төлөлтийн орлогоор 2183,7 сая төгрөг оруулахаар төлөвлөснөөс, гүйцэтгэлээр 1309,0 сая төгрөг оруулж орлогын төлөвлөгөөг 874,7 сая төгрөгөөр тасарсан байна.

Хүснэгт 6. СХС-ийн төлөвлөгөө гүйцэтгэл

| д.д | сумын нэр | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү | д.д | сумын нэр | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 1 | Галуут | 62.7 | 60.5 | (2.2) | 11 | Заг | 75.0 | 52.0 | (23.0) |
| 2 | Баян-Овоо | - | 5.4 | 5.4 | 12 | Баацагаан | 100.0 | 65.9 | (34.1) |
| 3 | Эрдэнэцогт | 65.4 | 86.8 | 21.4 | 13 | Бөмбөгөр | - | 58.7 | 58.7 |
| 4 | Бууцагаан | 48.0 | 30.2 | (17.8) | 14 | Өлзийт | 170.8 | 54.8 | (116.0) |
| 5 | Жинст | 130.0 | 86.3 | (43.7) | 15 | Хүрээмарал | 179.5 | 46.6 | (132.9) |
| 6 | Богд | 65.8 | 67.8 | 2.0 | 16 | Баянбулаг | 143.7 | 53.7 | (90.0) |
| 7 | Баянлиг | 80.0 | 72.7 | (7.3) | 17 | Шинэжинст | 68.2 | 38.3 | (29.9) |
| 8 | Баянговь | 132.1 | 35.3 | (96.8) | 18 | Баянцагаан | 116.2 | 100.3 | (15.9) |
| 9 | Гурванбулаг | 29.2 | 39.8 | 10.6 | 19 | Баян-Өндөр | 167.2 | 43.9 | (123.2) |
| 10 | Жаргалант | 127.4 | 60.3 | (67.0) | 20 | Баянхонгор сум | 422.5 | 249.8 | (172.7) |
| | | | | | | **СХСангийн дүн** | **2,183.7** | **1,309.2** | (874.5) |

Энэ нь Төсвийн тухай хуулийн дагуу орон нутгийн төсвийн бүрэлдэхүүнд ОНХС, СХС-гийн орлого, зарлагыг оруулан баталж, гүйцэтгэлийг тайлагнах болсноор сангуудаас олгосон зээлийн эргэн төлөлт хуваарийн дагуу төлөгдөөгүй, аймгийн ОНХС-аас болон сумдын СХС-аас олгосон зээлийг хугацаанд нь төлүүлээгүй, зээл авсан иргэд гэрээний үүргээ хэрэгжүүлээгүй, холбогдох аймаг, сумдын Засаг дарга нар үүргээ биелүүлж ажиллаагүйтэй холбоотой байна.

***Зорилт.2 Аймгийн ТЕЗ-ийн санхүүгийн нэгтгэсэн тайлангаар 67343,9 сая төгрөгийг зарцуулж батлагдсан төсөвт зардлыг 2301,3 сая төгрөгөөр хэмнэсэн байна.***

**2.1 Аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн 2017 оны төсвийн гүйцэтгэл:**

2017 онд аймгийн ИТХ-ын ээлжит хуралдаанаас төсөвт 3 удаа нэмэлт өөрчлөлт хийж, улсын төсвөөс авах санхүүгийн дэмжлэгээр 12251,4 сая, ОНХС-гийн шилжүүлгээр 2163,3 сая, тусгай зориулалтын шилжүүлгээр 38651,3 сая төгрөг

авах, орон нутгийн төсвөөс 8533,3 сая, төсөвт байгууллагын өөрийн орлогоор 4915,1 сая, тусгай зориулалтын шилжүүлэгийн байгууллагын өөрийн орлогоор 140,8 сая, урьд оны үлдэгдлээс 2990,0 төгрөг оруулж, нийт 69645,2 сая төгрөгийг зарцуулахаар төсөв батлагдсан байна.

*Төсөвт нэмэлт өөрчилөлт оруулахдаа Төсвийн тухай хуулийн 68.2-т "Төсвийн төслийг ИТХ-аар хэлэлцэх явцад нэмж тусгах ХО-ын төсөл, арга хэмжээг тухайн шатны төсвийг өргөн мэдүүлсэн этгээдээс энэ хуулийн 29 дүгээр зүйлд заасан шаардлагыг хангаж байгаа эсэх талаар санал, дүгнэлтийг авсны үндсэн дээр тусгана" гэсэн заалтын дагуу санал авсан эсэхийг шалгахад албан бичиг байхгүй байгаа тул аудитын явцад санал авч албан бичгийг хавсаргаж байхыг зөвлөв.*

Гүйцэтгэлээр улсын төсвөөс санхүүгийн дэмжлэгээр 12251,4 сая, тусгай зориулалтын шилжүүлгээр 38651,3 сая, Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас 2163,3 сая төгрөгийг авч, орон нутгийн орлогоос 9136,1 сая, үндсэн болон үндсэн бус үйл ажиллагааны орлогоор 4448,7 сая төгрөгийн орлого оруулж, урьд оны үлдэгдлээс 1009,7 мянган төгрөг авч, төсөвт байгууллагуудын зардлын зарцуулаагүй үлдсэн харилцах дансны үлдэгдэл 280,2 сая, тусгай зориулалтын шилжүүлгийн байгууллагын 36,4 сая төгрөгийг буцаан төвлөрүүлж, нийт 67343,9 сая төгрөгийг үйл ажиллааны зардалд зарцуулж, төсөвт зардлыг 2301,3 сая төгрөгөөр хэмнэсэн байна.

### Хүснэгт 7. Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2017 оны төсвийн гүйцэтгэл

/ төгрөгөөр /

| Эдийн засгийн ангилал | Үзүүлэлт | Тайлант оны | | |
|---|---|---|---|---|
| | | Батлагдсан төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү |
| 2 | НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН | 69,645.2 | 67,343.9 | -2301.3 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 64,202.1 | 62,769.2 | -1432.9 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 50,901.5 | 49,597.6 | -1303.9 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 28,529.3 | 28,506.9 | -22.4 |
| 210101 | Үндсэн цалин | 24,083.5 | 24,134.5 | 51.0 |
| 210102 | Нэмэгдэл | 2,150.2 | 2,101.6 | -48.6 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 73.1 | 67.9 | -5.2 |
| 210104 | Урамшуулал | 1,365.1 | 1,331.4 | -33.7 |
| 210105 | Гэрээт ажлын хөлс | 857.3 | 871.5 | 14.2 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 3,169.9 | 3,153.3 | -16.6 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 3,169.9 | 3,153.3 | -16.6 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 5,239.8 | 5,217.5 | -22.3 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 438.1 | 437.5 | -0.6 |
| 210302 | Түлш, халаалт | 4,482.3 | 4,462.3 | -20.0 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 268.8 | 267.3 | -1.5 |

| | | | | |
|---|---|---|---|---|
| 210304 | Байрны түрээс | 50.6 | 50.4 | -0.2 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 1,331.3 | 1,323.4 | -7.9 |
| 210401 | Бичиг хэрэг | 170.2 | 178.5 | 8.3 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 783.9 | 775.2 | -8.8 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 170.9 | 164.3 | -6.6 |
| 210404 | Ном, хэвлэл | 55.4 | 51.4 | -4.0 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 25.8 | 25.7 | -0.1 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 125.1 | 128.4 | 3.3 |
| **2105** | **Нормативт зардал** | 2,948.4 | 2,945.0 | -3.5 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 282.3 | 281.3 | -1.0 |
| 210502 | Хоол, хүнс | 2,333.8 | 2,330.4 | -3.4 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 332.2 | 333.2 | 1.0 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 1,023.1 | 1,019.7 | -3.4 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 168.4 | 167.0 | -1.3 |
| 210602 | Тавилга | 269.7 | 262.1 | -7.6 |
| 210603 | Хөдөлмөр хамгааллын хэрэглэл | 0.6 | 6.4 | 5.7 |
| 210604 | Урсгал засвар | 584.3 | 584.2 | -0.2 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 267.5 | 263.4 | -4.1 |
| 210701 | Гадаад албан томилолт | 1.8 | 1.8 | 0.0 |
| 210702 | Дотоод албан томилолт | 265.7 | 261.6 | -4.1 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 1,948.3 | 1,878.9 | -69.4 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 1,909.6 | 1,843.3 | -66.2 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 4.7 | 4.4 | -0.2 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 20.1 | 18.9 | -1.1 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 4.8 | 4.2 | -0.6 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 1.5 | 1.3 | -0.2 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 2.3 | 2.3 | 0.0 |
| 210807 | Газрын төлбөр | 1.9 | 1.5 | -0.4 |
| 210808 | Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж | 2.8 | 2.3 | -0.5 |
| 210809 | Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх | 0.7 | 0.6 | -0.1 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 6,443.9 | 5,289.6 | -1154.3 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 5,973.0 | 4,820.6 | -1152.4 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 470.9 | 469.0 | -1.9 |
| **212** | **ТАТААС** | 461.1 | 421.5 | -39.6 |
| **2122** | **Хувийн хэвшлийн байгууллагад олгох татаас** | 461.1 | 421.5 | -39.6 |
| 212201 | Хувийн хэвшлийн байгууллагад олгох татаас | 461.1 | 421.5 | -39.6 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 12,839.5 | 12,750.1 | -89.4 |
| **2131** | **Засгийн газрын урсгал шилжүүлэг** | 508.5 | 441.7 | -66.8 |
| 213101 | Засгийн газрын дотоод шилжүүлэг | 508.5 | 441.7 | -66.8 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 12,331.0 | 12,308.4 | -22.6 |
| 213202 | Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж | 1,019.8 | 1,081.6 | 61.8 |
| 213203 | Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж | 6,711.0 | 6,649.1 | -61.9 |
| 213204 | Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал | 74.0 | 70.9 | -3.0 |
| 213205 | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал | 1,098.6 | 1,095.2 | -3.4 |
| 213207 | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | 743.7 | 742.7 | -0.9 |
| 213208 | Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг | 1,498.5 | 1,498.7 | 0.2 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 1,185.5 | 1,170.1 | -15.4 |
| **22** | **ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ** | **5,443.1** | **4,574.7** | **-868.4** |
| **2200** | **Дотоод эх үүсвэрээр** | 5,443.1 | 4,574.7 | -868.4 |
| 220001 | Барилга байгууламж | 3,155.7 | 2,839.4 | -316.3 |

| | | | | |
|---|---|---|---|---|
| 223001 | Бусад хөрөнгө | 2,287.3 | 1,735.3 | -552.1 |
| | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | 69,645.2 | 67,423.4 | -2221.8 |
| **1310** | **УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | 38,651.3 | 38,614.9 | -36.4 |
| 131007 | Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих | 38,651.3 | 38,614.9 | -36.4 |
| **1320** | **ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | 22,984.7 | 24,359.8 | 1375.1 |
| 132001 | Орон нутгийн төсвөөс | 20,821.4 | 22,196.5 | 1375.1 |
| 132007 | Орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжих | 2,163.3 | 2,163.3 | 0.0 |
| **120004** | **ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС** | 8,009.2 | 4,448.8 | -3560.5 |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 1,705.1 | 1,389.3 | -315.8 |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 3,314.2 | 3,059.5 | -254.7 |
| 1200043 | Урьд оны үлдэгдлээс санхүүжих | 2,990.0 | - | -2990.0 |
| **4** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | - | 1,578.1 | 1578.1 |
| **5** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | - | 1,657.6 | 1657.6 |
| **61** | **БАЙГУУЛЛАГЫН ТОО** | 236 | 236 | 0 |
| 610001 | Төсвийн байгууллага | 236 | 236 | 0 |
| **62** | **АЖИЛЛАГСАДЫН ТОО** | 3674 | 3667 | -7 |
| 620001 | Удирдах ажилтан | 307 | 295 | -12 |
| 620002 | Гүйцэтгэх ажилтан | 2139 | 2180 | 41 |
| 620003 | Үйлчлэх ажилтан | 948 | 936 | -12 |
| 620004 | Гэрээт ажилтан | 280 | 256 | -24 |
| **63** | **СУРАЛЦАГЧДЫН ТОО (ЖИЛИЙН ДУНДЖААР)** | 20910 | 20831 | -79 |
| **630** | **ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛЬД СУРАЛЦАГЧИД** | 16043 | 15892 | -151 |
| 630001 | Төрийн өмчит ЕБС | 16043 | 15892 | -151 |
| **631** | **СУРГУУЛИЙН ӨМНӨХ БОЛОВСРОЛЫН БАЙГУУЛЛАГА** | 4867 | 4939 | 72 |
| 631001 | Төрийн өмчит СӨБ байгууллага | 4867 | 4939 | 72 |
| **64** | **ЭМЧЛҮҮЛЭГСЭДИЙН ТОО** | 0 | 16775 | 16775 |
| 640001 | Улсын эмнэлгээр хэвтэн эмчлүүлэгсдийн тоо | | 4114 | 4114 |
| 640002 | Улсын эмнэлгийн амбулатороор эмчлүүлэгсдийн тоо | | 12661 | 12661 |
| **65** | **ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ** | **3674** | **3667** | -7 |
| 650001 | Төрийн захиргааны албан хаагч (ТЗ) | 317 | 294 | -23 |
| 650002 | Төрийн тусгай албан хаагч (ТТ) | 7 | 3 | -4 |
| 650004 | СӨБ болон бага, дунд боловсролын албан хаагч (ТҮБД) | 1423 | 1443 | 20 |
| 650006 | Соёл урлагийн салбарын төрийн үйлчилгээний албан хаагч (ТҮСУ) | 132 | 134 | 2 |
| 650008 | Эрүүл мэндийн салбарын төрийн үйлчилгээний албан хаагч (ТҮЭМ) | 285 | 286 | 1 |
| 650009 | Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ) | 1068 | 1085 | 17 |
| 650010 | Гэрээт ажилтан | 280 | 259 | -21 |
| 650011 | Улс төрийн албан хаагч (УТ) | 162 | 163 | 1 |

Дээрх хүснэгтээс харахад 2017 онд урсгал үйл ажиллагааны зардлыг 1433,0 сая, хөрөнгийн зардлыг 868,3 сая төгрөгөөр төлөвлөснөөс дутуу зарцуулсан байна. Энэ нь СХС-гаас олгосон зээлийн эргэн төлөлтийн орлого 874,8 сая төгрөг санд дутуу оруулсантай холбоотой байна.

Төсөвт зардлыг нэр төрлөөр хэтрүүлээгүй ба зардлын гүйцэтгэлийг нэр төрлөөр авч үзвэл цалин хөлс 22,4 сая, НДШ-ийн зардлыг 16,6 сая, байр ашиглалттай холбоотой тогтмол зардлыг 22,3 сая, бусдаар гүйцэтгүүлэх ажил үйлчилгээний төлбөрийн орлогыг 69,4 сая, бараа үйлчилгээний бусад зардлыг 1154,3 сая, урсгал шилжүүлгийг 89,5 сая, хөрөнгийн зардлыг 868.3 сая төгрөгөөр тус тус зарцуулаагүй байна.

*Аудитаар сумдын ЗДТГ-ын үйл ажиллагааны зардлаас сумдын Цагдаагийн байгууллагын халаалт, түлшний зардалд 21,1 сая, шатахууны зардалд 10,1 сая, гэрэл цахилгааны зардалд 5,4 сая, сэлбэгийн зардалд 4,7 сая, бусад зардалд 4,7 сая, нийт 46,0 сая төгрөгийг зарцуулсан байна. Хүү торгуулийн орлогоор сумын орлогод 67,0 сая төгрөгийг оруулжээ.*

Цаашид Төсвийн тухай хуулийн 6.6.6-т “тухайн шатны төсвөөс санхүүжүүлэхээр хуулиар тогтоосон чиг үүргийг зөвхөн тухайн шатны төсвийн санхүүжүүлтээр хэрэгжүүлэх” гэсэн заалтын дагуу холбогдох байгууллагын зардлаас санхүүжүүлж байх зөвлөмжийг хүргүүлэв.

## 2.2 Орон нутгийн тусгай шилжүүлгийн талаар

Төсвийн тухай хуулийн 61 дүгээр зүйлийн 61.1-д “Аймаг, Нийслэлийн Засаг дарга Засгийн газрын дараах чиг үүргийг орон нутагт төлөөлөн хэрэгжүүлнэ” гэж заасан. Үүнд: Сургуулийн өмнөх боловсрол, Ерөнхий боловсрол, Соёлын үйлчилгээ, Нийтийн биеийн тамир, Эрүүл мэндийн анхан шатны тусламж үйлчилгээ, Газрын харилцаа,барилга хот байгуулалтын газар, Хүүхдийн хөгжил, хамгааллын үйлчилгээ хамрагдаж байна.

2017 онд тусгай зориулалтын шилжүүлгээр санхүүжих 113 байгууллагад 38651,3 сая төгрөгийн санхүүжилтийг олгосноос оны эцэст харилцах дансны зарцуулаагүй үлдэгдэл 37.4 сая төгрөгийг буцаан төвлөрүүлсэн нь ЕБС-ийн хүүхдийн тоог төлөвлөснөөс 151 хүүхдээр дутуу байгаагаас шалтгаалжээ.

**Хүснэгт 8. ТЗШ-ийн байгууллагын санхүүжилт** сая.төг

| Үзүүлэлт | Нийт дүн | Үүнээс: | | | |
|---|---|---|---|---|---|
| | | БСШУСЯ | ХАХНХЯ | ЭМЯ | БХБЯ |
| **Батлагдсан төсөв** | 38,651.3 | 32,807.2 | 145.4 | 5,454.5 | 244.1 |
| **Олгосон урсгал санхүүжилт** | 38,651.3 | 32,807.2 | 145.4 | 5,454.5 | 244.1 |
| **Нийт төвлөрүүлсэн** | 37.4 | 23.9 | 0.1 | 12.4 | 1.0 |
| **Үүнээс:Төсөвт /СЯ/** | 37.4 | 23.9 | 0.1 | 12.4 | 1.0 |

## 2.3 Тусгай сан

### 2.3.1 Замын сан:

Аймгийн ИТХ-ын хуралдааны 2016.12.02-ны өдрийн 4/02 дугаар тогтоолоор Автотээврийн болон өөрөө явагч хэрэгслийн албан татвараар 310.2 сая, орон нутгийн автозам ашигласны хураамжаар 90.0 сая төгрөг оруулахаар баталж, 2017.11.27-ы өдрийн 7/01 дугаар тогтоолоор Автотээврийн болон өөрөө явагч хэрэгслийн албан татварыг 428.7 сая, орон нутгийн автозам ашигласны хураамжийг 116.1 сая төгрөгөөр тодотгосон байна.

Замын санд Автотээврийн болон өөрөө явагч хэрэгслийн албан татварын орлогоос 374,2 сая төгрөг олгохоор төлөвлөж, 380.0 сая төгрөгийг замын санд санхүүжилтээр олгосон байна.




Орон нутгийн автозам ашигласны хураамжийг 116.1 сая төгрөгөөр төлөвлөж, гүйцэтгэлээр 117,4 сая төгрөг төвлөрч, орлогыг 101,1 хувиар буюу 1,3 сая төгрөгөөр давуулан биелүүлсэн байна.

Замын сангийн харилцах дансанд оны эхэнд 21.2 сая төгрөгийн үлдэгдэлтэй байгаа ба АТБӨЯХАТ-ын орлогоос 380.0 сая төгрөгийн санхүүжилт авч, авто зам ашигласны хураамжийн орлогоор 117.4 сая, нийт 517.1 сая төгрөгийн орлого төвлөрсөнөөс 25 батлагдсан төсөл, арга хэмжээнд 475.3 сая төгрөгийн зардал гаргаж 43.4 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна.

### 2.3.2 Орон нутгийн хөгжлийн сан:

2017 онд тус аймагт ОНХНС-гаас 2163,3 сая төгрөг хуваарилсныг аймгийн ИТХ-ын 2016.12.02-ны өдрийн хуралдааны 4/02 дугаар тогтоолоор анх 2980,0 сая төгрөгөөр баталж, орлогоор нэмж 816,7 сая төгрөг баталсныг аймгийн ИТХ-ын 2017.06.02-ны өдрийн хуралдааны 6/2 тоот тогтоолоор 2163,3 сая төгрөгөөр тодотгон 816,7 сая төгрөгөөр бууруулан баталсан байна.

2017 онд улсын төсвөөс аймгийн ОНХНС-нд 2163,3 сая төгрөгийн санхүүжилт олгосоныг аймгийн ОНХС-д 1551,1 сая, сумдын ОНХС-д 28,3 хувь буюу 612,2 сая төгрөгийг олгосон байна.

2017 оны эхэнд 892,5 сая төгрөгийн үлдэгдэлтэй байсан ба ОНХНСангаас 2163,3 сая төгрөгийн санхүүжилт, орон нутгийн төсвөөс 373,0 сая, хандив, тусламж бусад орлогоор 2640.8 сая, нийт 5177.1 сая төгрөгийн орлого орж, 5322.2 сая төгрөгийг төсөл, арга хэмжээний зардалд зарцуулж, оны эцэст 747.4 сая төгрөгийн мөнгөн хөрөнгийн үлдэгдэлтэй байна.

Үүнээс санд орсон орлогыг тодруулвал АТБӨЯХАТ-ын хувь хэмжээг нэмэгдүүлснээс орох орлого 54,5 сая, хандив, бусад орлогоор уул уурхайн компаниудаас аймгийн ОНХС-д 1910.2 сая, сумдын ОНХС-д 676,1 сая төгрөгийн орлого төвлөрсөн байна.

ОНХСангийн хөрөнгийг зарцуулахдаа холбогдох хууль тогтоомж, журмыг хэрэгжүүлээгүй зөрчил илэрч байна. Тухайлбал:

- *Шинэжинст, Богд, Баянцагаан зэрэг ихэнх сумд Сангийн сайдын 2016 оны 415 дугаар тушаалаар батлагдсан "Төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөлт, санхүүжилт, хяналт, тайлагналтын журам"-ын хавсралт 4-д заасан "урсгал засварын ажлын гүйцэтгэл"-ийг холбогдох маягтын дагуу гаргаж, баталгаажуулаагүй байхад Төрийн сан гүйлгээ хийж санхүүжилтийг гүйцэтгэгчид олгож, журам зөрчсөн байна.*
- *Гурванбулаг сум Сумын ИТХ-аас батлагдаагүй төсөл арга хэмжээ буюу Цагдаагийн тасагт бэлэн бусын тоног төхөөрөмжийг 2,3 төгрөгөөр гэрээ байгуулан 2,0 төгрөгийн санхүүжилт олгосон байна.*
- *Өлзийт сумын ОНХС "Баян тээх" ХХК-иас гэрээнд тусгасан зардлаас зураг төсвийн үнийн 3,8 сая , захиалагчийн хяналтын зардлын 2,0 сая төгрөгийг суутган тооцоогүй илүү шилжүүлсэн.*
- *Бөмбөгөр сумын ОНХС Нийгмийн халамж, асрамж үйлчилгээнд батлагдсан 1,0 сая төгрөгийг НИК ХХК-д шилжүүлсэн анхан шатны баримт байхгүй.*
- *Бөмбөгөр сум ОНХС-ийн хөрөнгөөр бэлтгэсэн 18,0 сая төгрөгийн өвсийг ЗДТГ-ын тайланд тусгасан атлаа сангийн тайланд авлагаар бүртгэсэн.*
- *Бөмбөгөр сум ажлын урьдчилгаанд шилжүүлсэн 25,3 сая, Жаргалант сум худаг засварын 14.8 сая, Богд сум сургуулийн засварын зураг төсвийн үнэ 9.0 сая, Баянцагаан сум багийн төвд гэрэлтүүлэг тавих ажилд 9,5 сая төгрөгийг тус тус олгож хөрөнгийг бусад эргэлтийн хөрөнгөөр бүртгээгүй байгаа нь Сангийн сайдын 2016 оны 415 дугаар тушаалаар батлагдсан " Төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөлт, санхүүжилт, хяналт, тайлагналтын журам"-ын 6.1-т " УТХО-аар хийгдсэн ажил нь ...орон нутгийн өмчид заавал бүртгэх бөгөөд барилга байгууламжийг барьж дуусах хүртэл....захиалагч байгууллага эргэлтийн бус хөрөнгөөр бүртгэн санхүүгийн тайландаа тусгана..." гэсэн заалтыг зөрчсөн*
- *Галуут сумын ОНХС Сумын ЗДТГ-ын автомашины засварын 2,6 сая төгрөгийн зардлыг санхүүжүүлсэн.*
- *Заг сум тайлант онд олгосон малжуулах зээлийн 16,2 сая төгрөгийг авлагаар бүртгээгүй байна.*

Аймаг, сумдын ОНХС-ийн зарцуулалтад хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар 10 байгууллагад 80,7 сая төгрөгийн зөрчил илэрч 13 зөвлөмж, 9 байгууллагын санхүүгийн тайланд 116,0 сая төгрөгийн залруулга хийж, 7

байгууллагад 12,2 сая төгрөгийн төлбөрийн акт, 3 байгууллагад 26,1 сая төгрөгийн зөрчил арилгах албан шаардлага хүргүүлсэн байна.

**2.3.4 Сум хөгжүүлэх сан:**

Сум хөгжүүлэх сангийн зээлийн эргэн төлөлтийн орлогоор анх 815,5 сая төгрөг оруулахаар төлөвлөснийг 1368,2 сая төгрөгөөр нэмэгдүүлэн 2183,7 сая төгрөг оруулахаар тодотгож, гүйцэтгэлээр санд 1309,0 сая төгрөг оруулж орлогын төлөвлөгөөг 59,9 хувиар буюу 874,7 сая төгрөгөөр тасалсан байна.

Баянхонгор аймгийн 20 сумын Сум хөгжүүлэх сангийн дансанд 2017 оны эхэнд 659.2 сая төгрөгийн үлдэгдэлтэй байсан ба сангаас олгосон зээл, зээлийн хүүгийн эргэн төлөлтийн орлогоос 1309,0 сая төгрөгийн орлого орж, ЖДҮ эрхлэгч 189 иргэн, аж ахуйн нэгжид 1104,5 сая төгрөгийг зээлд олгож, сангийн үйл ажиллагааны зардалд 19,3 сая, бусад зардалд 12,1 сая төгрөг зарцуулан оны эцэст 832,3 сая төгрөгийн мөнгөн хөрөнгийн үлдэгдэлтэй байна.

2017 оны эцсийн байдлаар санхүүгийн нэгтгэсэн тайланд СХС-гаас хувь хүмүүст олгосон зээлийн 3791,2 сая төгрөгийн авлагатай байна.

**Жинст, Баян-Өндөр, Бууцагаан, Бөмбөгөр, Богд, Баян-Овоо, Баянговь** сумын Сум хөгжүүлэх сангийн 2017 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 18.1.2.б-д заасны дагуу ИТХ-аас СХС-гийн төсвийг батлаагүй, Төсвийн тухай хуулийн 41.2.2, Засгийн газрын 216 оны 153 дугаар тогтоолоор баталсан "Сум хөгжүүлэх сангийн хөрөнгийг бүрдүүлэх, зарцуулах, тайлагнах, хяналт тавих журам"-ын 5.4 дэх заалтыг зөрчсөн нь "Үнэн зөв байдал" гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байснаас "**Хязгаарлалттай**" санал дүгнэлт авсан байна.

Сум хөгжүүлэх сангийн зарцуулалтад хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар зээлийн хүү, зээлийн авлагыг тайланд зөрүүтэй тусгасан, сангаас зориулалт бусаар хөрөнгө зарцуулсан, зээлийн эргэн төлөлтийн хугацаа хэтэрсэн зэрэг зөрчил илэрсэн байна. Үүнд:

Сумдын СХС-ийн зарцуулалтад хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар 8 байгууллагад 12,1 сая төгрөгийн зөрчил арилгах 11 зөвлөмж, 4 байгууллагын санхүүгийн тайланд 9,8 сая төгрөгийн алдааг залруулж, 7 байгууллагад 158,4 сая төгрөгийн төлбөрийн акт тогтоон, 16 байгууллагад 668,5 сая төгрөгийн зөрчил арилгах албан шаардлага хүргүүлсэн байна.

- *Баянговь сум сумын Соёлын төвийн барилгын гүйцэтгэгч болох ЭЙ АР БИ СИ ХХК-д 10.0 сая төгрөгийн зээлийг сум хөгжүүлэх сангаас олгосон.*
- *Жаргалант сум Шүүхээр шийдвэрлүүлэн мөнгө нь өмгөөлөгчийн дансанд орж ирсэн 3 иргэний Сум хөгжүүлэх сангийн зээлийн төлбөр болох 2,8 сая төгрөгийг өмгөөлөгч СХС-ийн дансанд төвлөрүүлээгүй байна.*
- *Бөмбөгөр сумын СХС-гаас зээл авсан 15 хүн 23,1 сая , Өлзийт сумын СХС-аас зээл авсан 19 хүн 11,3 сая, Хүрээмарал сумын СХС-аас зээл авсан 2 иргэн 13,8 сая төгрөгийн зээлийг 2017 онд төлөх хуваарь хийсэн боловч зээлийн гэрээний дагуу төлөлгүй зээлийг хугацаа хэтрүүлсэн зөрчилд төлбөрийн акт тогтоосон байна..*
- *Баян-Овоо сум Сум хөгжүүлэх сангаас сумын ИТХ-аас сангийн төсвийг баталж өгөөгүй байхад ЗДТГ-ын дарга нь төсвийн захирагчийг төлөөлөн, иргэн Б.Батцэнгэлтэй 12.0 сая төгрөгийн дүн бүхий "Эрх зүйн туслалцаа үзүүлэх" гэрээ байгуулан 12.0 сая төгрөгийн санхүүжилтийг бүрэн олгосон байхад, иргэн гэрээнд заасан үүргийг биелүүлээгүй байна. Уг асуудлыг хууль хяналтын байгууллагаар шалгуулж шийдвэрлүүлэх гэсэн хугацаатай албан шаардлагыг сумын Засаг даргад нь хүргүүлсэн болно.*
- *Баяновоо сум 136,0 сая, Жаргалант сум 49,9 сая, Баянцагаан сум 15,6 сая, Баянлиг сум 17,1 сая, Заг сум 56,9 сая, Бууцагаан сум 44,1 сая, Бөмбөгөр сум 92,7 сая, Шинэжинст сум 15,7 сая, Богд сум 9,9 сая, Баянбулаг сум 54,8 сая, Баянговь сум 86,8 сая, Жинст сум 38,4 сая, Баацагаан 38,1 сая нийт 635,5 сая төгрөгийн зээлийн эргэн төлөлтийн хуваариас хугацаа хэтэрсэн зээлдэгч нараар зээлийг төлүүлэх, холбогдох хуулийн байгууллагад шилжүүлэх албан шаардлагыг хүргүүлэв.*

Сумын Засаг дарга нар Сум хөгжүүлэх сангийн 2017 оны орлого, зарлага, зээл авсан болон зээлийн үлдэгдлийн мэдээллийг Засгийн газрын 2016 оны 153 дугаар тогтоолоор баталсан "Сум хөгжүүлэх сангийн хөрөнгийг бүрдүүлэх, зарцуулах, тайлагнах, хяналт тавих журам"-ын 5.4[1] дэх заалтыг зөрчснөөс Монгол банкны зээлийн мэдээллийн санд оруулах нөхцлийг бүрдүүлээгүй байгаа тул аймгийн Засаг даргад зөвлөмж хүргүүлэв.

## 2.4 Төсвийн шилжүүлэг

- ***Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж***: Нийгмийн халамжийн сангаас тэтгэвэр, тэтгэмжид 7730,8 сая, үйл ажиллагааны зардалд 41,9 сая төгрөг зарцуулахаар төлөвлөснөөс тэтгэвэр тэтгэмжид 7727,5 сая, үйл ажиллагааны зардалд 41,9 сая төгрөг зарцуулж, нийгмийн халамжийн тэтгэвэр тэтгэмжийг гүйцэтгэлээр нь санхүүжүүлсэн байна.
- **Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал:** Үдийн цай хөтөлбөрт 1078,5 сая төгрөг батлаж, гүйцэтгэлээр 1075,1 сая төгрөгийг зарцуулж, батлагдсан төсвийг 3,4 сая төгрөгөөр хэмнэсэн нь хүүхэд өдрийн гүйцэтгэлээр санхүүжүүлсэнтэй холбоотой байна.

[1] "Сум хөгжүүлэх сангийн хөрөнгийг бүрдүүлэх, зарцуулах, тайлагнах, хяналт тавих журам"-ын 5.4 " Сумын Засаг дарга сангийн орлого, зарлагын гүйцэтгэлийн тайланг... аймгийн Засаг даргад хүргүүлнэ"

- **Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж:** Зардлыг 743,7 сая төгрөгөөр төлөвлөж, гүйцэтгэлээр 742,7 сая төгрөгийн тэтгэмжийг олгож 1,0 сая төгрөгийг хэмнэжээ.
- **Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг:** 2017 онд хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг олгоход 1498,5 сая төгрөг баталснаас, 1498,7 сая төгрөгийн тэтгэмжийг олгосон байна.
- **Нэг удаагийн тэтгэмж шагнал урамшуулалын зардал:**Тайлант онд нэг удаагийн тэтгэмж урамшуулалын зардалд 1185,5 сая төгрөг баталснаас 1170,1 сая төгрөгийн тэтгэмжийг тогтоолын дагуу олгож, зардлыг 15,4 сая төгрөгөөр хэмнэсэн байна.

### 2.5 Ангилагдаагүй зардал

Ангилагдаагүй зардлын дансанд 2017 онд 2445,1 сая төгрөгийн санхүүжилт олгосон ба аймгийн ИТХ-ын хуралдааны 2016.12.02-ний өдрийн 4/2 тоот тогтоолоор ангилагдаагүй зардалд 13 хөтөлбөр арга хэмжээнд 472,7 сая төгрөг батлаж 2017 оны 1,6,11,12 дугаар сарууддад 4 удаа тодотгол хийж, нийт 2311,6 сая төгрөгийн 42 төсөл, арга хэмжээг санхүүжүүлэхээр баталснаас гүйцэтгэлээр 2310,8 сая төгрөг олгожээ.

Тухайн дансаар ахмадын байгууллагын санхүүжилтийн 75,2 сая, нийтийн тээврийн санхүүжилтийн 18,0 сая төгрөгийн гүйлгээ дамжсан бөгөөд дансны нэр зөрүүтэйгээс буцсан 491,9 сая төгрөгийн гүйлгээ гарсан байна.

ИТХ-ын тогтоолоор батлагдсан гадаад арга хэмжээний зардалд олгосон 2 удаагийн томилолтоос 1,3 сая, аймгийн Биеийн тамир, спортын газраас 0,2 сая, Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн газраас 3,0 сая, Эрүүл мэндийн газраас 0,1 сая, нийт 4,6 сая төгрөгийн санхүүжилтийн үлдэгдлийг буцаан дансанд төвлөрүүлж, оны эцэст дансны зарцуулаагүй үлдэгдлийн 41,1 сая төгрөгийг орон нутгийн ерөнхий орлогын дансанд буцаан төвлөрүүлсэн байна.

Ангилагдаагүй зардлаас аймгийн ИТХ-аар батлаж орон нутгийн өмчит “Нью майнинг” ХХК-д үйл ажиллагааны зардалд 26,0 сая, “Үйлдвэржилт хөгжлийн корпораци” ХХК-д төрийн ажлыг төрийн бус байгууллагаар гүйцэтгүүлэхээр 65,0 сая төгрөгийн санхүүжилт олгосон байна.

## 2.6 Орон нутгийн нэмэлт санхүүжилтийн дансны талаар

Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2017 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлд заасны дагуу орон нутгийн нэмэлт дансаар 1822,7 сая төгрөгийн орлого орж 50,7 сая төгрөгийг буцаан төвлөрүүлж 1772,0 сая төгрөгийг зарцуулсан байна.

Нэмэлт санхүүжилтийн дансанд хандив тусламжийн орлогоор 141,9 сая, ангилагдаагүй нөөц хөрөнгөөс зохих шийдвэрийн дагуу тухай төсвийн захирагчид 211,2 сая төгрөг хуваарилсан, дээд шатны төсвийн захирагчаас 1416,0 сая, үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлогоос 53,6 сая төгрөг нийт 1822,7 сая төгрөгийн орлого орсон байна.

Дээрх орлогоос цалин хөлс болон нэмэгдэл урамшил, НДШ-д 72,3 сая, бараа үйлчилгээний бусад зардалд 1699,7 сая, нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулалд 97,1 сая төгрөгийг зарцуулсан байна.

**Аудит хийхэд учирсан хүндрэл бэрхшээл:**

Баянхонгор аймгийн ТЕЗ-ийн төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийхэд аймгийн ТЕЗ-ийн санхүүгийн нэгтгэсэн тайланд батлагдсан төлөвлөгөөг төсвийн мэргэжилтнүүд дутуу бичилт хийснээс аудит хийсэн төсвийн шууд захирагч нарын санхүүгийн тайлангийн төлөвлөгөө Э-Тайланд буруу татагдсаныг дахин засварлаж, тулгалт хийхэд цаг хугацаа их зарцуулсан.

Цаашид батлагдсан төлөвлөгөөний нэгтгэлийг дараа жилийн 1-р сарын 25-ны дотор Сангийн яаманд хүргүүлж нэгтгүүлэх шаардлагатай байгаа тул аймгийн ТЕЗ-д зөвлөмж хүргүүлэв.

Аудитаар нийт 533,6 сая төгрөгийн зөрчил илэрч зөрчлийг арилгах зөвлөмжийг хүргүүлэв.

## АУДИТЫН ДҮГНЭЛТ

1. Орон нутгийн орлогоор анх 8297.9 сая төгрөг оруулахаар баталсныг Төсвийн тухай хуулийн 34.2.1-т заасны дагуу төсөвт 5150.7 сая төгрөөр өөрчилөлт оруулан 2017 онд 13584,8 сая төгрөгийн орлого орж, төлөвлөгөөг 101,0 хувиар биелүүлсэн, төлөвлөгөө биелэсэн хэмжээгээр нь төсвийн зарлагыг нэмэгдүүлж байгаа нь төсвийг зорилтод арга хэмжээнд үр дүнтэй зарцуулахад эрсдэл дагуулж байна

2. Сумын санхүүгийн албадын дарга нар сумын ИТХ-ын хуралдааны төсөв баталсан тогтоолыг тухай бүр нь аймгийн СТСХ, Татварын хэлтэст хүргүүлж, сумын орлогын төлөвлөгөөний дүнг тохироогүйгээс 9 сум 6 төрлийн татварын орлогыг 103,0 сая, аймгийн ИТХ-аар баталсан орон нутгийн өмч хөрөнгө борлуулсны орлогын 430.6 сая төгрөгийг тус тус аймгийн Татварын хэлтсийн төлөвлөгөөнд оруулаагүй байна.

3. Сум хөгжүүлэх сангийн зээлийн эргэн төлөлтийн хугацаа хэтэрсэн авлагыг барагдуулах талаар сумдын ТЕЗ нар тодорхой арга хэмжээ, ажил зохион байгуулаагүйгээс орлогын төлөвлөгөө 59,9 хувиар буюу 874,7 сая төгрөгөөр тасарсан байна.

4. Аймаг, сумын ИТХ-аар батлагдсан орон нутгийн орлогын төлөвлөгөөг төсвийн мэргэжилтнүүд Фискаль программд бүрэн шивж сан үүсгээгүйгээс Э-Тайланд буруу татагдаж аймгийн ТЕЗ-ийн санхүүгийн нэгтгэсэн тайлангийн төлөвлөгөөг дахин засварлагдсан, санхүүгийн нэгтгэсэн тайлангийн үзүүлэлтэд салбараар нь дүн шинжилгээ хийгээгүй байна.

5. Аймгийн ТЕЗ-ийн санхүүгийн нэгтгэсэн тайлангаар 67343,9 сая төгрөгийг зарцуулж батлагдсан төсөвт зардлыг 2301,3 сая төгрөгөөр хэмнэсэн нь ТШЗ болон сумыд ТЕЗ нь гэрээгээр хүлээсэн үүргээ бүрэн биелүүлээгүйгээс СХС, ОНХС-гийн зээлийн буцаан төвлөрүүлэлт, ОНХС-гийн хөрөнгөөр хийхээр баталсан төсөл арга хэмжээ хэрэгжээгүйтэй холбоотой байна.

6. Сумдын ЗДТГ-ын үйл ажиллагааны зардлаас суманд үйл ажиллагаа явуулж байгаа Цагдаагийн байгууллагын урсгал зардалд 46.0 сая төгрөгийг зарцуулсан нь Төсвийн тухай хуулийн 6.6.6 дахь заалтыг зөрчсөн байна.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Б.МӨНХБАТ

## АУДИТЫН ЗӨВЛӨМЖ

Аймгийн Засаг дарга, төсвийн ерөнхийлөн захирагч Г.Батжаргал,
аймгийн ЗДТГ-ын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга
С.Байгалмаа нарт

Баянхонгор аймгийн төсвийн Ерөнхийлөн захирагчийн 2017 оны төсвийн гүйцэтгэлийн тайланд хийсэн аудитын дүнд үндэслэн дараахь зөвлөмжийг өгч байна.

1. Аймгийн Засаг дарга Төсвийн тухай хуулийн 68.2-т заасны дагуу төсвийн төслийг ИТХ-аар хэлэлцэх явцад нэмж тусгасан арга хэмжээ дээр энэ хуулийн 29 дүгээр зүйлийн шаардлага хангаж байгаа эсэхэд санал дүгнэлтээ бичгээр өгч байх.
2. Төсвийн тухай хуулийн 34.2-т заасны дагуу төсвийн тодотголыг боловсруулж, тухайн шатны ИТХ-д өргөн барьж, аймаг, сумын ИТХ-ын хуралдааны төсөв баталсан тогтоолыг тухай бүр авч аймгийн Татварын хэлтсийн төлөвлөгөөний дүнд өөрчлөлт оруулж байх.
3. Орон нутгийн орлогын батлагдсан төлөвлөгөөний нэгтгэлийг хугацаанд нь Фискаль программд үнэн зөв шивж, сан үүсгэн хадгалж Сангийн яаманд хүргүүлэн, төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, тайлагналын програм хоорондын мэдээлэл солилцох боломж нөхцлийг сайжруулах.
4. Сум хөгжүүлэх сангийн зээлийн эргэн төлөлтийн орлогын төлөвлөгөөг биелүүлж, сангийн хөрөнгийг бүрэн төвлөрүүлэх арга хэмжээг авч ажиллах.
5. Сумдын ЗДТГ-ын дарга нар Төсвийн тухай хуулийн 6.6.6 дахь заалтыг хэрэгжүүлж ажиллах.
6. Аймгийн ЗДТГ-ын СТСХ-ийн төсвийн мэргэжилтэнүүд аймгийн төсвийн орлого, зарлага болон салбарын үзүүлэлт, төсвийн гүйцэтгэлийн тайланд шинжилгээ хийж тайлбар тодруулга гарган, орлого нэмэгдүүлэх, төсвийн үр ашгийг сайжруулах талаар судалгаа гарган, аймгийн бодлого шийдвэрт тусгуулж байх.

Зөвлөмжийн мөрөөр зохиосон ажил, түүний хэрэгжилт, үр дүнг 2018 оны 7 дугаар сарын 25-ны дотор Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Б.МӨНХБАТ

Баянхонгор аймаг орон нутгийн төсөв -ын 2017 оны нийт орлогын судалгаа

Дээд шатны байгууллага: _____Баянхонгор аймаг орон нутгийн төсөв___________________

/сая.төг/

| Код | Орлого /нэр төрөөр/ | Өмнөх оны гүйцэтгэл | Орлого төвлөрүүлэлт | | | Орлогын зарцуулалт | | | Үлдэгдэл |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Батлагдсан | Гүйцэтгэл | Зөрүү | Төсөвт төвлөрүүл-сэн | Урсгал үйл ажиллагаа-ны зардалд | Хөрөнгө бэлтгэхэд | |
| 1 | **Үйл ажиллагааны орлогын дүн /Нийт мөнгөн орлого/** | **64,593.8** | **69,645.2** | **80,303.2** | (10,658.0) | **368.3** | **70,541.1** | **5,508.2** | **3,917.2** |
| 11 | ***Татварын орлого*** | *7,198.4* | *7,641.1* | *7,992.6* | *(351.5)* | - | *7,100.1* | - | *892.5* |
| 1180 | Бусад нийтлэг төлбөр хураамж | 7,198.4 | 7,641.1 | 7,992.6 | (351.5) | | 7,100.1 | | 892.5 |
| 11001 | ЦХТАО | 4,763.1 | 4,977.1 | 5,268.7 | (291.6) | | | | |
| 110101 | Буцаан олголт | (802.3) | (772.0) | (771.4) | (0.6) | | | | |
| 11002 | Үйл ажиллагааны орлого | 415.7 | 686.7 | 632.2 | 54.5 | | | | |
| 11003 | Хөрөнгийн орлого | 68.3 | 72.5 | 202.9 | (130.4) | | | | |
| 11004 | Хөрөнгө борлуулсаны орлого | 727.5 | 430.6 | 202.6 | 228.0 | | | | |
| 113001 | ҮХЭХАТатвар | 186.9 | 200.0 | 247.6 | (47.6) | | | | |
| 113002 | Бууны татвар | 38.0 | 46.1 | 52.7 | (6.6) | | | | |
| 113003 | АТӨЯХАТ | 359.8 | 428.7 | 399.7 | 29.0 | | | | |
| 118001 | УТХ | 213.0 | 221.2 | 231.7 | (10.5) | | | | |
| 118006 | Түгээмэл тархацтай АМАТөлбөр | 9.6 | 14.7 | 8.4 | 6.3 | | | | |
| 118009 | Хог хаягдлын хураамж | 2.7 | 282.9 | 301.9 | (19.0) | | | | |
| 118011 | Бусад татвар хураамж | 23.9 | | | - | | | | |
| 118101 | Газрын төлбөр | 104.6 | 120.0 | 149.8 | (29.8) | | | | |
| 118102 | Газрын дуудлага худалдаа | 2.9 | 2.5 | 8.2 | (5.7) | | | | |
| 118202 | .Ан, амьтан агнуурын нөөц ашигласны | 619.3 | 520.0 | 603.0 | (83.0) | | | | |
| 118203 | ус рашаан ашигласны төлбөр | 430.0 | 403.0 | 438.9 | (35.9) | | | | |
| 118301 | Бусад татвар хураамж | 28.1 | | 6.7 | (6.7) | | | | |
| 118304 | .Нохойны татвар | 7.3 | 7.1 | 8.9 | (1.8) | | | | |
| 12 | ***Татварын бус орлого*** | *2,947.8* | *5,948.1* | *16,820.0* | (10,871.9) | *20.5* | *14,553.8* | - | *2,245.7* |
| 1200 | Нийтлэг бус татварын орлого | 2,947.8 | 5,948.1 | 16,820.0 | (10,871.9) | 20.5 | 14,553.8 | - | 2,245.7 |
| 120003 | Төсөвт байгууллагын өөрийн орлого | 2,265.6 | 5,055.9 | 15,676.6 | (10,620.7) | 20.5 | 13,410.4 | | 2,245.7 |
| 120004 | Бусад орлого /Хүү торгууль/ | 682.2 | 892.2 | 1,143.4 | (251.2) | | 1,143.4 | | |
| 13 | ***Тусламж санхүүжилтийн орлого*** | *54,447.6* | *56,056.0* | *55,490.6* | 565.4 | *347.8* | *48,887.2* | *5,508.2* | *779.0* |
| 1310 | Улсын төсвөөс санхүүжих | 52,572.2 | 53,066.0 | 53,066.0 | - | 297.1 | 46,557.5 | 5,464.0 | 779.0 |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 12,138.9 | 12,251.4 | 12,251.4 | - | 260.7 | 9,075.8 | 2,914.9 | 31.6 |
| 1310.. | ОНХС-гийн санхүүжилт | 4,737.8 | 2,163.3 | 2,163.3 | - | | 1,415.9 | | 747.4 |
| 1311007 | Тусгай зориулалтын шилжүүлгийн | 35,695.5 | 38,651.3 | 38,651.3 | - | 36.4 | 36,065.8 | 2,549.1 | |
| 1311 | Нэмэлт санхүүжилтийн орлого | 1,875.4 | - | 1,822.7 | (1,822.7) | 50.7 | 1,727.8 | 44.2 | - |
| 131101 | Хандив тусламжаас /Төсвийн тухай хууль /ТТХ/-47.1.1/ | | | 141.9 | (141.9) | | 97.7 | 44.2 | |
| 131102 | Гадаад төсөл хөтөлбөрөөс /ТТХ-47.1.2/ | | | - | - | | - | | |
| 131103 | Ангилагдаагүй нөөц хөрөнгө /ЗГ-ын нөөц сан, ЗДНХөрөнгө/ /ТТХ-47.1.3/ | 64.0 | | 211.2 | (211.2) | | 211.2 | | |
| 131104 | Дээд шатны төсөв захирагчаас /ТТХ-47.1.4/ | 1,811.4 | | 1,416.0 | (1,416.0) | | 1,416.0 | | |
| 131105 | Үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлогоос /ТТХ-47.1.5/ | | | 53.6 | (53.6) | 50.7 | 2.9 | | |
| 1320 | Орон нутгийн төсвөөс санхүүжих | - | 2,990.0 | - | 2,990.0 | - | - | - | - |
| 132004 | Урьд оны үлдэгдлээс | | 2,990.0 | | 2,990.0 | | | | |
| 1340 | Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих | - | - | 601.9 | (601.9) | - | 601.9 | - | - |

Жич: 1.Өөрийн байгууллагад хамааралтай орлогыг Сангийн сайдын 2015 оны 341 дүгээр тушаалаар батлагдсан журмын /Хүснэгт 2а/ кодоор сонголт хийж, оруулна.

Судалгаа гаргасан:

Ахлах удитор ____________ А.Цэзням

Аудитор ____________ Б.Цэрэнчимэд

Аудитор ____________ Ж.Өсөхбаяр

Хянасан:

Аудитын менежер ____________ Д.Цэцэгмаа

Дарга, Тэргүүлэх аудитор ____________ Б.Мөнхбат

Зардал №Ц/01

**Баянхонгор аймгийн ТЕЗ-ийн 2017 оны орон тоо, цалингийн сангийн судалгаа**

Дээд шатны байгууллага: ___________________________

/сая.төг/

| № | Байгууллагын нэр | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | | | | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | | | | Ажиллагсдын тоо | | | | | | | Тайлбар |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | Өмнөх оны гүйцэтгэл | 2017 оны | | | Өмнөх оны гүйцэтгэл | 2017 оны | | | Өмнөх оны гүйцэтгэл | 2017 оны | | | | | | |
| | | | | | | | | | | | | | Үүнээс: | | | | |
| | | | Төсөв | Гүйцэтгэл | Зөрүү | | Төсөв | Гүйцэтгэл | Зөрүү | | Төсөв | Гүйцэтгэл | Удирдах | Гүйцэтгэх | Үйлчлэх | Гэрээт | |
| А | Б | 1 | 2 | 3 | 4=3-2 | 5 | 6 | 7 | 8=7-6 | 9 | 10 | 11 | 12 | 13 | 14 | 15 | 16 |
| | Баянхонгор аймгийн ТЕЗ | 28638.7 | 28529.3 | 28506.9 | -22.4 | 3147.9 | 3169.9 | 3153.3 | -16.6 | 3663 | 3674 | 3667 | 295 | 2180 | 936 | 256 | |
| | | | | | | | | | | | | | | | | | |
| | | | | | | | | | | | | | | | | | |

Судалгаа гаргасан:

Ахлах удитор А.Цэзням

Аудитор Б.Цэрэнчимэд

Аудитор Ж.Өсөхбаяр

Хянасан:

Аудитын менежер Д.Цэцэгмаа

Дарга, Тэргүүлэх аудитор Б.Мөнхбат

Зардал №Ц/02

## Харьяа байгууллагын 2017 оны орон тоо, цалингийн сангийн судалгаа

Төсвийн ерөнхийлөн захирагч /эсвэл төсвийн Төвлөрүүлэн захирагч/: Баянхонгор аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагч

/сая.төг/

| № | Харьяа байгууллагын нэр | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | | | | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | | | | Ажиллагсдын тоо | | | | | | | Тайлбар |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | Өмнөх оны гүйцэтгэл | 2017 оны | | | Өмнөх оны гүйцэтгэл | 2017 оны | | | Өмнөх оны гүйцэтгэл | 2017 оны | | | | | | |
| | | | | | | | | | | | | | Үүнээс: | | | | |
| | | | Төсөв | Гүйцэтгэл | Зөрүү | | Төсөв | Гүйцэтгэл | Зөрүү | | Төсөв | Гүйцэтгэл | Удирдах | Гүйцэтгэх | Үйлчлэх | Гэрээт | |
| А | Б | 1 | 2 | 3 | 4=3-2 | 5 | 6 | 7 | 8=7-6 | 9 | 10 | 11 | 12 | 13 | 14 | 15 | 16 |
| | Галуут | 1,117.2 | 1,130.7 | 1,127.8 | (2.9) | 126.0 | 126.4 | 124.2 | (2.2) | 144 | 144 | 144 | 9 | 79 | 38 | 18 | |
| | Баян-Овоо | 709.3 | 692.0 | 691.6 | (0.4) | 77.0 | 77.0 | 76.5 | (0.5) | 86 | 84 | 84 | 15 | 43 | 23 | 3 | |
| | Эрдэнэцогт | 961.9 | 975.4 | 978.1 | 2.7 | 106.9 | 106.8 | 103.2 | (3.6) | 115 | 115 | 114 | 14 | 73 | 27 | | |
| | Бууцагаан | 1,269.3 | 1,256.1 | 1,255.8 | (0.3) | 137.1 | 137.3 | 137.1 | (0.2) | 155 | 156 | 157 | 15 | 94 | 46 | 2 | |
| | Жинст | 808.7 | 777.8 | 777.3 | (0.5) | 86.1 | 86.8 | 87.2 | 0.4 | 110 | 99 | 93 | 13 | 63 | 13 | 4 | |
| | Богд | 850.6 | 857.1 | 855.0 | (2.1) | 93.9 | 93.8 | 93.3 | (0.5) | 103 | 103 | 98 | 14 | 64 | 19 | 1 | |
| | Баянлиг | 1,231.6 | 1,223.6 | 1,222.0 | (1.6) | 133.5 | 133.4 | 132.7 | (0.7) | 149 | 151 | 151 | 10 | 101 | 38 | 2 | |
| | Баянговь | 930.3 | 912.8 | 911.3 | (1.5) | 201.0 | 100.7 | 100.5 | (0) | 250 | 250 | 124 | 14 | 85 | 25 | 0 | |
| | Гурванбулаг | 886.1 | 890.4 | 890.4 | - | 96.4 | 96.4 | 96.2 | (0.2) | 118 | 118 | 125 | 14 | 81 | 18 | 12 | |
| | Жаргалант | 842.1 | 812.8 | 812.4 | (0.3) | 89.5 | 89.5 | 89.6 | 0.1 | 113 | 109 | 102 | 11 | 62 | 27 | 2 | |
| | Заг | 762.8 | 751.7 | 751.7 | - | 83.1 | 83.8 | 83.1 | (0.7) | 104 | 102 | 96 | 9 | 62 | 18 | 7 | |
| | Баацагаан | 977.3 | 965.3 | 964.9 | (0.4) | 108.4 | 108.5 | 107.4 | (1.1) | 136 | 137 | 128 | 15 | 69 | 30 | 14 | |
| | Бөмбөгөр | 955.7 | 955.5 | 955.1 | (0.4) | 107.8 | 107.9 | 107.8 | (0.1) | 124 | 130 | 126 | 15 | 65 | 22 | 24 | |
| | Өлзийт | 997.8 | 1,005.4 | 1,005.1 | (0.3) | 110.7 | 110.8 | 110.1 | (0.7) | 123 | 124 | 121 | 14 | 59 | 42 | 6 | |
| | Хүрээмарал | 799.8 | 810.1 | 808.8 | (1.3) | 90.3 | 90.3 | 90.0 | (0.3) | 112 | 115 | 111 | 13 | 58 | 20 | 20 | |
| | Баянбулаг | 856.8 | 834.5 | 836.4 | 1.9 | 92.9 | 92.9 | 92.6 | (0.3) | 107 | 107 | 113 | 12 | 65 | 16 | 20 | |
| | Шинэжинст | 852.2 | 843.4 | 839.8 | (3.6) | 94.2 | 94.2 | 93.3 | (0.9) | 120 | 120 | 121 | 13 | 63 | 29 | 16 | |
| | Баянцагаан | 980.9 | 963.7 | 964.4 | 0.6 | 107.8 | 107.8 | 106.0 | (1.8) | 128 | 129 | 129 | 12 | 72 | 26 | 19 | |
| | Баян-Өндөр | 918.8 | 918.1 | 914.1 | (4.0) | 103.4 | 103.5 | 102.0 | (1.5) | 125 | 126 | 123 | 8 | 68 | 28 | 19 | |
| | Баянхонгор сум | 8,108.5 | 8,118.5 | 8,114.5 | (4.0) | 905.4 | 905.4 | 904.8 | (0.6) | 1002 | 1027 | 1051 | 27 | 699 | 305 | 20 | |
| | Баянхонгор төв | 2,821.0 | 2,834.3 | 2,830.3 | (4.0) | 196.6 | 316.7 | 315.6 | (1.1) | 239 | 271 | 356 | 28 | 155 | 126 | 47 | |
| | **Төсвийн шууд захирагчийн санхүүгийн тайлангийн дүн** | **28,638.7** | **28,529.3** | **28,506.9** | **(22.4)** | **3,147.9** | **3,169.9** | **3,153.3** | **(16.6)** | **3663** | **3717** | **3667** | **295** | **2180** | **936** | **256** | |
| **ТЕЗ-ийн санхүүгийн нэгтгэсэн тайлангийн дүн** | | **28,638.7** | **28,529.3** | **28,506.9** | **(22.4)** | **3,147.9** | **3,169.9** | **3,153.3** | **(16.6)** | **3,663** | **3,717** | **3,667** | **295** | **2,180** | **936** | **256** | |

Жич: Энэ судалгааг төсвийн Ерөнхийлөн болон Төвлөрүүлэн захирагчдын харьяа байгууллага бүрээр гаргана.

Судалгаа гаргасан:

Ахлах удитор А.Цээням

Аудитор Б.Цэрэнчимэд

Аудитор Ж.Өсөхбаяр

Хянасан:

Аудитын менежер Д.Цэцэгмаа

Дарга, Тэргүүлэх аудитор Б.Мөнхбат

Зардал № НТ/03

## Баянхонгор аймгийн ТЕЗ-ийн 2017 оны Нэмэлт төсвийн судалгаа

Дээд шатны байгууллага: Баянхонгор аймгийн Засаг дарга_______________

/сая.төг/

| № | Салбарын болон байгууллагын нэр | 2016 оны гүйцэтгэл | 2017 оны гүйцэтгэл | Товч тайлбар |
|---|---|---|---|---|
| А | Б | 1 | 2 | 3 |
| **1** | **Орлогын дүн, Үүнээс:** | **1,875.4** | **1,822.7** | |
| 1.1 | Хандив тусламжаас /Төсвийн тухай хууль /ТТХ/-47.1.1/ | | 141.9 | |
| 1.2 | Гадаад төсөл хөтөлбөрөөс /ТТХ-47.1.2/ | | | |
| 1.3 | Ангилагдаагүй нөөц хөрөнгө /ЗГ-ын нөөц сан, ЗДНХөрөнгө/ /ТТХ-47.1.3/ | 64.0 | 211.2 | |
| 1.4 | Дээд шатны төсөв захирагчаас /ТТХ-47.1.4/ | 1,811.4 | 1,416.0 | |
| 1.5 | Үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлогоос /ТТХ-47.1.5/ | | 53.6 | |
| **2** | **Зарцуулалтын дүн, Үүнээс:** | **1,875.4** | **1,822.9** | |
| 2.1 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 26.9 | 65.5 | |
| 2.2 | Ажил олгогчоос НД-д төлөх шимтгэл | 12.9 | 6.8 | |
| 2.3 | Бараа үйлчилгээний бусад зардал | 1,642.6 | 1,602.8 | |
| 2.4 | Татаас ба урсгал шилжүүлэг | | 50.7 | |
| 2.4.1 | Шагнал урамшуулал | | | |
| 2.4.2 | Нэг удаагийн тэтгэмж, урамшуулал | 193.0 | 97.1 | |

Судалгаа гаргасан:

Ахлах удитор А.Цээням

Аудитор Б.Цэрэнчимэд

Аудитор Ж.Өсөхбаяр

Хянасан:

Аудитын менежер Д.Цэцэгмаа

Дарга, Тэргүүлэх аудитор Б.Мөнхбат

Зардал № ГТ/04

**Баянхонгор аймгийн ТЕЗ-ийн 2017 оны гадаад албан томилолтын зардлын судалгаа**

Дээд шатны байгууллага: Баянхонгор аймгийн Засаг дарга

| № | Өмнөх оны гүйцэтгэл /сая.төг/ | 2017 он | | | Тайлбар /Томилолтын зардлын эх үүсвэрийг бичих/ |
|---|---|---|---|---|---|
| | | Гадаад томилолтоор ажилласан хүний тоо | Гадаад томилолтын төсөв /сая.төг/ | Гүйцэтгэл /сая.төг/ | |
| | *0* | *12* | *1.8* | *19.2* | ангилагдаагүй зардлын нөөцөөс |
| **Дүн** | | 12 | 1.8 | 19.2 | |

Судалгаа гаргасан:

Ахлах удитор А.Цээням

Аудитор Б.Цэрэнчимэд

Аудитор Ж.Өсөхбаяр

Хянасан:

Аудитын менежер Д.Цэцэгмаа

Дарга, Тэргүүлэх аудитор Б.Мөнхбат

Зардал № ТГ/05

## Баянхонгор аймгийн ТЕЗ-ийн 2017 оны төсвийн гүйцэтгэлийн тайлан /дэлгэрэнгүй/

Дээд шатны байгууллага: Баянхонгор аймгийн Засаг дарга________________________

/сая.төг/

| ТГ-ийн тайлан-гийн Код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | 2017 он | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | Анх батлагдсан | Тодотгосон төсөв /2/ | Гүйцэтгэл | Зөрүү |
| А | Б | 1 | 2 | 3 | 4 | 5=4-3 |
| 2 | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | 61,948.7 | 60,264.5 | 69,645.2 | 67,343.9 | (2,194.9) |
| 21 | **УРСГАЛ ЗАРДАЛ** | 60,015.9 | 55,973.7 | 64,202.1 | 62,769.1 | (1,326.6) |
| 210 | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 45,781.1 | 44,401.6 | 50,901.4 | 49,597.6 | (1,303.8) |
| 2101 | Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил | 28,638.7 | 28,729.9 | 28,529.3 | 28,506.9 | (22.4) |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх | 3,148.0 | 3,180.3 | 3,169.9 | 3,153.3 | (16.6) |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 4,627.4 | 5,330.9 | 5,239.8 | 5,217.5 | (22.3) |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 1,194.8 | 1,163.2 | 1,331.3 | 1,323.4 | (7.9) |
| 2105 | Нормативт зардал | 2,750.3 | 3,077.3 | 2,948.4 | 2,944.9 | (3.5) |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 554.6 | 201.8 | 1,023.0 | 1,019.7 | (3.3) |
| 2107 | Томилолт, зочны зардал | 226.1 | 225.0 | 267.5 | 263.4 | (4.1) |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 1,211.2 | 1,152.7 | 1,948.3 | 1,878.9 | (69.4) |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 1,163.2 | 1,113.9 | 1,909.5 | 1,843.4 | (66.1) |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 7.5 | 4.8 | 4.7 | 4.4 | (0.3) |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 13.3 | 21.8 | 20.1 | 18.9 | (1.2) |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 4.4 | 4.9 | 4.8 | 4.2 | (0.6) |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 1.1 | 1.6 | 1.5 | 1.3 | (0.2) |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 14.9 | - | 2.3 | 2.3 | - |
| 210807 | Газрын төлбөр | 1.7 | 2.1 | 1.9 | 1.5 | (0.4) |
| 210808 | Банк, СБ-ын үйлчилгээний хураамж | 4.4 | 2.9 | 2.8 | 2.3 | (0.5) |
| 210809 | Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх | 0.7 | 0.7 | 0.7 | 0.6 | (0.1) |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 3,430.0 | 1,340.5 | 6,443.9 | 5,289.6 | (1,154.3) |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 3,351.8 | 1,277.9 | 5,973.0 | 4,820.7 | (1,152.3) |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 78.2 | 62.6 | 470.9 | 468.9 | (2.0) |
| 211 | ХҮҮ | - | - | - | - | - |
